

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

Жинэ Зүрхэс Найр





ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

Эхнэр Зүүрх
Сайр



*Месс Тэгээрсэн
Увс Багш Чин Хай*

*Франц, Гэгээн мартин төв
2008 оны 9-р сарын 6*

Зориулал Эрмэл

Хамгаас хайрт Их Багш минь ээ!

Орчлонгийн Нигүүлсэнгүй Их Багш Тандаа мэхийн ёслохын сацуу Таны яруу найргийн хэмжээлшгүй арвин сангаас дээжлэн орчуулж, хүмүүсийн хүртээл болгох үйлсийг маань залж чиглүүлж өгсөнд тань бид чин сэтгэлээсээ талархаж байна. Таны шүлэг бүхэн хаврын цэцэгсийн анхилам үнэр адил ялдам урсгалаар хамаг амьтны ухамсарт нэвтэрч, сүнс бүрийн нигүүлсэнгүй чанарыг сэрээн, мөнхийн хайрын эрэлд бүгдийг дагуулах бөлгөө.

Таны яруу найргийн мөнхийн хайрын адислалд хүмүүн төрөлхтөн үүрд гэрэлтэн гэгээрэх болтугай.

Бүхий л төрөлтөн бээр Таны хязгааргүй нигүүлслээр адислагдан Гэгээрлийн Эрэг рүү нэн даруй эргэн хүрэх болтугай.

Эрин Зууны Хайр яруу найргийн цоморлигоо
Диваажингийн эрэг дээрээс шүлэглэсэн
Өгөөмөр Их Багш Танаа дээдийн хүндэтгэл өргөө.
Сувдан шигтгээт, эрдэнэсийн үгс тань
Сэтгэл зүрхэнд урсан орж ирэхүйеэ
Яруу найргийн их мөрөн ай түмэн жил гялалзаж,
Ямархан олон өнгөөр гэгээ татуулан мяралзана вэ.
Урсгалд нь аялагчдыг гэтэлгэгч сал
Уугуул Сууринд нь аваачнам буюу.

Таныхаа хязгааргүй хайранд адислагдсан
Шавь нар чинь мэхийн ёслол.

Талархал

Яруу найргийн энэхүү цоморлигийг өлгийдөн авахад хүчин зүтгээж, хамаг олон болгоон таашаах тансаг бүтээл болгохын төлөөнөө эгэлгүй ихээр хичээн зүтгэсэн сайхан сэтгэлт бүхий л хүмүүс хийгээд Тэнгэрийн Адислалд Шүлэгч бээр чин сэтгэлийн талархлаа дэвшүүлж байна.

♥♥ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Монгол хэлнээ орчуулсан
Дугарсүрэнгийн Гүн-Үйлс

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн Монгол дахь төвийн Номын баг

Хянан хэвлүүлсэн
Маналын Тэгшжаргал

Хавтасны загварыг зохиомжилсон
Bie Lee

Хавтасны нэрийг урлан бичсэн
Гришаагийн Жааханхүү

Уран сайхны зохиомжуудыг бүрдүүлсэн
Diệp Quốc Bình

Зураг дүрсүүдийг буулгасан
Worldwide Photography Group, Supreme Master Television

Зургуудыг засварласан
Wang Bor Tang, Yu Hui-Chun

Уран бүтээлчидтэй холбоо тогтоосон

Formosa Taipei Center, Formosa Changhua Center,
and Supreme Master Ching Hai International Association

Түүнчлэн авьяас чадварын хувь нэмсэн дараах уран бүтээлчид болон байгууллагуудад талархал дэвшүүлье!

НОМЫН ХАВТАСНЫ БИЧЛЭГИЙГ УРЛАН ТОЛИЛУУЛСАН
Trần Đình Thục

ГЭРЭЛ ЗУРГУУДЫГ
Trần Đình Thục, Joshua Tan, DREAMSTIME Inc., DepositPhotos SXC,
Courtesy of NASA, ESA, S.Beckwith (STScI) & the HUDF Team

СЭТГЭГДЭЛ ҮЛДЭЭСЭН

Ерөнхий Захирал асан Karl Min Ku, Яруу Найрагч Phạm Thiên Thư, Хөгжмийн Зохиолч Fred Karlin, Хөгжмийн Зохиолч Bill Conti, Хөгжмийн Зохиолч Phạm Duy, Хөгжмийн Зохиолч Nguyễn Văn Tú, Хөгжмийн Зохиолч Phạm Mạnh Cường, Хөгжмийн Зохиолч Vũ Đức Sao Biển, Хөгжмийн Зохиолч Chu Minh Kỳ, Хөгжмийн Зохиолч Trần Quang Lộc, Хөгжмийн Зохиолч Tô Thanh Tùng, Хөгжмийн Зохиолч Kim Tuấn, Профессор Chang Kuang-Bin, Профессор Chiang I-Han, Яруу Найрагч Wu Sheng, Зохиолч Lin Wu Hsien, Ерөнхий эрхлэгч Lin Hsu Wen Er, Уран Бүтээлч Tang Mei-Yun, Зохиолч Kang Yuan.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Намтар Хайрын Зам



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол соёл, зан заншлын элдэв ялгаа саадыг үл ажран хайр энэрлээ түгээж байдаг дэлхий дахинаа алдар суу нь түгсэн оюун санааны аугаа залуурч, уран бүтээлч, хүмүүнлэг үйлстэн билээ. Төв Ау Лак (Вьетнам) нутагт мэндэлсэн Тэрбээр хожим нь Европт боловсрол эзэмшиж, тэндээ Улаан Загалмайн нийгэмлэгт ажиллаж байжээ. Удалгүй дэлхийн аль ч газар зовлон зүдгүүр ялгаагүй байдгийг ухаарснаар үүнээс гэтлэн гарах арга замыг хайж олох нь Түүний амьдралын эрхэм дээд зорилго болов. Тэрбээр тухайн үед Герман эмчтэй гэр бүл болж, аз жаргалтай амьдарч байсан ч хэн хэндээ амаргүй шийдвэрийг гаргаж, нөхрийнхөө өгөөмөр зөвшөөрлөөр гэрлэлтээ цуцлууулж, энэхүү эрхэм зорилгоо гүйцэлдүүлэхээр гэгээрлийг эрэх аяндаа мордсон юм. Улмаар Энэтхэгийн Гималайн ууланд нэгэн жинхэнэ Их Багшаас дотоодын гэрэл, аялгууны бясалгалыг уламжлан авч суралцсан бөгөөд хожим нь түүнийгээ бясалгалын Гуань Инь арга хэмээн нэрийджээ. Ийнхүү хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгасны эцэст Тэрбээр Төгс Гэгээрэлд хүрч чадсан билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн гэгээрлийн сургаалийг үндэс болгосон Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг 1980 онд байгуулагджээ. Гэгээрлийг эрэлхийлэгч олны чин хүсэлт ёсоор Тэрбээр Гуань Инь бясалгалын аргаа бусадтай хуваалцаж, дотоод дахь бурханлиг чанараа нээн илрүүлэхэд хүмүүсийг дэмжин урамшуулдаг болсон юм. Удалгүй Америк, Европ, Ази, Австрали, Африк тивүүдээс болон Нэгдсэн Үндэсний Байгууллагаас урилга илгээн Их Багшаас ном айлтгахыг хүсэх болжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай мөн янз бүрийн хүнд хэцүү нөхцөлд ядарч зовсон олонд нигүүлсэнгүй зүрх сэтгэлээр анхаарал халамж тавьж байдаг билээ. Түүний энэрэл асрал нь бүхий л саад тотгорыг даван туулж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, азай буурлууд, дүрвэгсэд болон хоригдогсод, бие махбодийн болон сэтгэцийн өвчтэй хүмүүс, орон гэргүйчүүд, ахмад дайчид гээд хэнийг ч алгасалгүй хүрч чаддаг билээ. Дэлхийн дулаарлын үр дагавар илэрч буй энэ яаралтай цаг үед Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүмүүнлэгийн үйлсэд сая сая долларыг өгөөмрөөр хандивласан бөгөөд Нийгэмлэгийнхээ гишүүдийг ч бас байгалийн гамшигт нэрвэгдсэн хүмүүст хүрч очин, туслахаар явахыг уриалдаг юм. Түүний нинжин сэтгэлийн хайр халамжийг энэ гарагийн үнэт баялаг болох байгаль орчин хийгээд амьтад ч бас хүртсээр байдаг билээ. Тэрбээр өгөөмөр нинжин үйлсээрээ даян дэлхийн олон сая хүний зүрх сэтгэлд хүрсэн төдийгүй бусдын дагах үлгэр дуурайлал болсоор байна. Тэрбээр уран зураг, гэрлийн бүрхүүл, хувцас болон үнэт эрдэнийн загвар зэрэг бүтээлүүдээсээ олсон орлогоо Бурханы хүүхдүүдэд гачигдсан цагт нь туслах эрхэм зорилгодоо зориулдаг билээ.

Саяхан Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай “Шувууд миний амьдралд”, “Миний амьдрал дахь ноход”, “Эрхэм ариун амьтад” зэрэг номуудыг бичиж хэвлүүлсэн нь олон улсад шилдэг борлуулалттай номын жагсаалтыг тэргүүлж байна. Дэлхийн олон хэл дээр орчуулагдсан эдгээр номнууд нь бидний анд нөхөр болох эрхэм амьтдын өгөөмөр сэтгэл, хариу нэхдэггүй хайрыг онцгой сайхнаар дүрслэн гаргаж, далд мэдрэмж, бясалгалын билэг увдисаар бидний анд нөхөд болох эрхэм амьтдын сэтгэлийн гүн хөдлөл, бодол санааг нээн харуулсан байдаг.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай сайн үйлс бүтээгч хувь хүмүүсийг алдаршуулж, тэдний үлгэр дууриаллаар замнах бусад хүмүүсийг урамшуулан зоригжуулахын тулд 2006 оны 3 дугаар сард Гэрэлт Дэлхийн

Гарамгай Удирдагч шагналыг санаачлан бий болгосон юм. Мөн дараахан нь Гэрэлт Дэлхийн Баатарлаг Үйлстэн, Гэрэлт Дэлхийн Энэрэнгүй Үйлстэн, Гэрэлт Дэлхийн Шударга Үйлстэн, Гэрэлт Дэлхийн Ололт зэрэг нэр хүндтэй цуврал шагналуудыг санаачилсан бөгөөд, үүгээрээ манай Дэлхийн энх тайван, эв нэгдэл, гоо үзэсгэлэнд үлгэр жишээ, ажил үйлсээрээ жинтэй хувь нэмэр оруулсан улс орон, байгууллага, хувь хүмүүсийг шагнаж ирсэн билээ. Тухайлбал Словени улсын хоёр дахь ерөнхийлөгч, доктор Жанез Дрновшек; АНУ-ын 45 дахь дэд ерөнхийлөгч, 2007 Нобелийн Энх Тайвны шагналт, НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо(IPCC)-ны гишүүн Аль Гор; НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо(IPCC)-ны тэргүүн бөгөөд Энэтхэгийн Эрчим Хүч, Эрдэс Баялгийн Хүрээлэн(ITER)-гийн тэргүүн, НҮБ-ын 2010 оны UN-NABITAT Хотуудын Илтгэл шагналын эзэн, доктор Ражендра К.Пачаури; Сансар Судлалын Үндэсний Төвийн (NASA) Сансар Судлалын Хүрээлэнгийн тэргүүн, 2009 оны Карл Густаф Россби судалгааны шагналын эзэн, доктор Жеймс Е.Хансен; Британийн алдарт Приматологич, доктор Жейн Гүүдал нарын олон хүн эдгээр шагналыг хүртсэн байна.

Бидний эрхэм анд болох амьтад ч мөн адил өөрийн амийг эрсдүүлэн байж хүний амь аварсан эрхэм бөгөөд аминч бус үйлсээрээ Гэрэлт Дэлхийн Баатарлаг Үйлстэн, Гэрэлт Дэлхийн Ухаантан зэрэг шагналуудыг хүртэж, эр зориг, оюун ухаан, хайрын үйл хэрэг, үлгэр жишээг харуулсан байдаг юм.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай манай дэлхийд оюун санааны хувьд ч, эд материалын хувьд ч маш их зүйлийг зориулсан билээ. Тэрбээр хүмүүнлэг ажил үйлсийнхээ төлөө аливаа гавъяа шагнал горьддоггүй хэдий ч дэлхий дахины олон төр засаг, хувийн байгууллагууд түүнд хүндэт шагналуудаа харамгүй олгож ирсэн бөгөөд үүнд 2006 оны Гусигийн Энх Тайвны Шагнал, 27 дахь Телли шагналын Тэргүүн байрын Мөнгөн цом

(2006), Лос Анжелесын Хөгжмийн Долоо Хоногийн Сайшаалын гэрчилгээ (2002), Дэлхийн Оюун Санааны Жолоодогчийн Шагнал (1994), Дэлхийн Хүмүүнлэг Иргэн Шагнал (1994) зүй ёсоор багтдаг билээ. Түүнчлэн АНУ-ын төр засгаас жил бүрийн 10 дугаар сарын 25 болон 2 дугаар сарын 22-ныг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” хэмээн тэмдэглэж байхаар зарласан юм. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийд өргөсөн тусламж, чин зүтгэл нь хэдэн сая төрийн тэргүүн, эгэл иргэдийн чин сэтгэлийн талархлыг хүлээн эдүгээг хүртэл үргэлжилсээр байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд ухаалаг зоригтойгоор санаа тавьдаг нэр хүндтэй анхдагчдын нэгэн юм. Тэрбээр чухамдаа байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах талаар 20 гаруй жил ярьж сануулан хэлж ирсэн билээ. Тэрээр Өөрөөр Амьдарцгаая, SOS-Дэлхийн дулаарал хэмээх ухуулга, сэрэмжлүүлгийн олон нийтийн ажлыг санаачлан эхлүүлж, гарагийн өнөөгийн хямралын язгуур шалтгаан, түүний гол шийдэл нь болох аж төрөхүйн энэрэнгүй веган хэв маягийг олон нийтийн анхаарлын төвд авч ирэхийн төлөө олон уулзалт бага хуралд



Товч илгээлт

Бурхан болоод Дээд Сүнсний тухай ярихдаа Их Багш Бурхан эр эсвэл эм хүйстэй алин болох маргаанаас зайлсхийж, хүйсний ялгаа заадаггүй дараах нэр томъёо хэрэглэж байхыг бидэнд санал болгодог юм.

She+He=Hes (Bless гэдэгтэй адил дуудна.)

Her+Him=Hirm (Firm гэдэгтэй адил дуудна.)

Hers+His=Hiers (Dear гэдэгтэй адил дуудна.)

Жишээлбэл: Бурхан хийх болохоороо, Тэрээр (Hes) юмыг өөрийнх нь (Hirmself), Түүний(Hiers) хүсэл зоригт нийцэж тохирч байхуйцаар хийдэг.

Тарчиг

• Зориулал Өргөл	iv
• Талархал	v
• Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн намтар Хайрын Зам	vi
• Өмнөтгөл	xii
• Толилуулга	xiv
• Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Яруу Найргийн Талаарх Алдарт Уран Бүтээлчдийн Сэтгэгдэл	xvi
Тэргүүн хэсэг - Залуу Нас, Төрөлх Нутгаа Хайрлах Хайр	
01. Гэр минь*	2
02. Санаанд илхэн зун*	4
03. Тэр л өдөр*	8
04. Тэр л нэгэн өдөр*	12
Дэд хэсэг - Хамаг Амьтныг Хайрлах Хайр	
05. Гөлөгний үг*	18
06. Шувууны үг*	20
07. Тооройн үг*	23
08. Төсөөлөөд нэг бодооч!	27
Гутгаар хэсэг - Цаг Хугацаа, Орон Зайг Ялгуусан Хайр	
09. Эрин зууны хайр*	32
10. Шөнийн зүүд*	40
11. Цагийн сүүдэр*	42
12. Хаа эртийн хайр*	44
13. Сэтгэл зүрхний эзэн*	46
14. Төрөл ялгуусан хайр	50
15. Ханхүүд	54
16. Ханхүүд баяр хүргэмү	60
17. Лондон	62
18. Амраг хайр минь	66
19. Үнэр ялдам харгуй	68
20. Ханхүү болон хаант улс	72
21. Харууслыг хуваалцахуй	74

Дөтгөөр Хэсэг - Тухайлан Зориулбай	
22. Алтанлянхуа*	81
23. Саёнара*	83
24. Хоанг Кам-дзориулав*	85
25. Thu Но-дзориулав*	87
26. Ли Еэн Пионг-дзориулав*	89
27. Тай Ханг-дзориулав*	91
28. Фам Дуй-дзориулбай*	91
29. Эгэл баатар	92

Тавдугаар хэсэг - Тэнгэрлиг Хайр	
30. Сэрж сэхээрэгтүн!*	99
31. Битгийяваач!*	104
32. Будда-гийн чулуун хөшөөтэй ярилцсан минь*	108
33. Чулуун Будда-тай хөөрөлдөхүй	110
34. Үгүй дээ, хайр минь*	112
35. Бие биесээн хайрлацгаая!*	114
36. Цаглашгүй хайр*	119
37. Хайртай шүү хэмээн таныг надад хэлэхэд	122
38. Ая, Диваажингийн шувуу мину!	124
39. Наран тань даадуулму	126
40. Ая, саран мину	130
41. Алсын одод мину!	134
42. Би	136
43. Төөрөг заяагаа магтан дуулья!	138
44. Бурхан чамд хичнээн хайртай билээ!	140
45. Аятай тавтай амраарай, алдрай мину	146
46. Ахин учрах маань хэзээ вэ?*	152

• Дуулагдсан шүлэг найргууд	155
• Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн шүлгийн цоморлиг	156
• Бидэнтэй холбоо барих хаяг	164

* Эх бичвэр нь Ау Лак (Вьетнам) хэл дээр



Толууца

Сэтгэлдээ нэгдмэл чанар, Үнэний мөнхийн гэрэл оршоогч Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хуурмаг хоосон хүмүүний амьдралыг зүрх сэтгэлээрээ туулахдаа хорвоогийн хүмүүсийн зовлон хийгээд уй гашууг мэдэрч, гүнээ харамсдаг ажугу.

Бүүр түүрхэн энэ ертөнцөд амьдрал гэгч заримдаа эрэг өөд буцаж очин хайрт гэрээ олохыг мөрөөсөн, задгай тэнгисийн гүнд дайвалцах, замаа алдаад удсан завь лугаа уйт, чимээгүй бөлгөө. Хайрт нь харин Диваажингаас холын холд нисэн одсон шувууны сүүдэр лүгээ байх ажугу. Үл тайтгарам мөрөөсөл л үлдэх буюу.

*Урьд шөнө би зүүдэллээ.
Унтах ор, дэрлэх дэрнээс
Анхил зандан агаарт үнэртэв.
Үргэлж бид хамт,
Үнэн хайр минь мөнх.
Амраг сэтгэлийн мөрөөсөл хөврөв.*

(Шөнийн зүүд)

“Эрин Зууны Хайр” ном нь Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн чамин тансаг 46 шүлгийг багтаасан цоморлиг юм. Хүмүүний амьдрал, эгэл хийгээд хөөрхийлөлтэй амьтдын заяа тавиланг энэрэн болгоогч нэгэн сүнсний хайр, дуурсал, хөг аялгуу тэргүүтэн эл бүтээлд цогцолжээ. Эрхэм дээдийн ч бай, эгэл жирийн ч бай элдэв хувирал дүүрэн энэ амьдралд хэн ч үхэх төрөхийн хүрднээс булгаж зайлах нь үгүй. Энэ барьцгүй амьдралын далайд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүмүүний зовлон бэрхийг гүнзгий мэдэрч ойлгодог билээ. Тийм ч учраас Түүний яруу найрагт нь сэтгэлийн шаналал, энэрэл нигүүлсэл нэвт шингэсэн байдаг.

*Уйт зовлонд шаналагсдын төлөө мэгшисээр
Урсах нулимс эгшиж, урсах үг цөөрч дээ.*
(Сэрж сэхээрэгтүн!)



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай шүлэг найраглалдаа сэтгэлийн хөдөлгөөн, оюун санааны дэвшил, өдөр тутмын эгэл амьдралыг тун энгийнээр донж тааруулан өгүүлдэг. Түүний шүлэг найргийн өнгө аяс нь уян зөөлөн, гүн гүнзгий агаад сүнс бүрийн нуугдан буй булан тохойг гэрэлтүүлэн гийгүүлэх сарны туяа мэт бөлгөө. Зарим үес зовлонгийн далайг хөндлөн гулд туулж, аз жаргалын эрэг дээр очихыг хүсэмжлэн буй, хайр тээсэн уйтгарт завь ч юм шиг; нөгөө үес хоромхон зуурын энэ хорвоогийн бүх зам дээр бидний сэтгэлийг сэргээгч зуны бороо мэт буюу. Яруу найрагч маань хүн төрөлхтөн гарваль чанараа ухааран сэхээрч, өгөөмөр эрхэм амьдрахуйн мөрийг дагаж, Үнэнтэй нүүр тулаасай; энэ л гариг дэлхийгээ хамаг амьтан ялгалгүй энх амгалан, эв зохиролтой зэрэгцэн орших Газрын Диваажин болоосой хэмээсэн чин сэтгэлийн залбирлаа өргөжээ.

*Аяа, ах минь, сэрж сэхээрэгтүн!
Агуу их тэнгисийн дээгүүр бардамхан алхагтун.
Асан дүрэлзэх наран өөд эгцлэн харж,
Амьтан бүхнийг аврахын төлөөсөнд өөрийгөө зориулагтун!*
(Сэрж сэхээрэгтүн!)

Яруу найрагт хайртай хэн бүхнийг “Эрин Зууны Хайр” цоморлигийн шүлэг найргийг толилон болгоож, бөхөшгүй хайр болон гэгээрлийн ертөнцөөр аялж, Гэрээсээ хол одсон Нэгэний сэтгэлд оршин буй “хайртайгаа эргэн золгохын” туйлын мөрөөслийг мэдэрнэ үү хэмээн сэтгэлийн цацал өргөмүй.

Гайхамшигт яруу найргийн бадгуудаа хайр, итгэл найдварын дундаршгүй ундарга болгон дэлхийн хүмүүс бидэнд бэлэглэсэн Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Тандаа бид дээдийн дээд талархлаа дэвшүүлж байна.

*Аялгуут далайн чимээнд Диваажингийн салхин сэвших
Амгалан гэгээн ертөнцдөө эгэн бид очноо.*
(Ахин учрах маань хэзээ вэ?)


~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн
Номын Хэлтэс

Жич: Яруу найргийн цоморлигийн ишлэлийг налуу үсгээр бичсэн болно.



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Яруу Найргийн
Тадлаархи Ардарт Уран Бүтээгчдийн Сэтгэгдэл

Phạm Thiên Thư бол Ау Лакын цэцэн билигт найрагчдын нэг билээ. Тэрээр эх орныхоо утга зохиолын их сан хөмрөгт “Цагаан цэцгийн агуй”, “Эртний Хуанг Ти (Yore-ийн Hoang Thi)” зэрэг мөнхийн бүтээлүүдээ өргөж, хувь нэмрээ оруулжээ. Сац бас тэр бээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найргийг уншаад нэн их хөхин урамшиж, Түүнд зориулан өндөр дээд хайр хүндэтгэл, гүн утга шингэсэн нэгэн яруу найргийг тэрлэсэн нь тэр бөлгөө.



Зэн Их Багш хийгээд яруу найрагч, Төгс Гэгээрсэн Чин Хай Танаа хүндэтгэлтэйгээр зориулмай.

Аяа, “Цагийн сүүдэр” мину,
Шувуудын мөр эргийн элснээ үлдэж,
Шөнийн манан сарны алтан туяанд цайвалзахуй
Цахирмаа цэцэг анхилуун үнэрээ түгээнэм!

Эрээн мяраан дэлхийд хоромхон үзэгдэх өглөөний од
Эгэлгүй шинэхэн үнэрийг эрэлхийлэн гялбалзана.
Ай, наран – ертөмций,
Аяа, утга төгс болоод утга нь үгүй хоосоон!

Үнэр бүгтхэн усны дусал,
Үнэндээ хэлбэр дүрсгүй бясалгал – сарны туяанд
цайвалзах цэцэрлэг ээ!

Phạm Thiên Thư

2009 оны 10-р сарын 29

Яруу найраг, дуу хөгжим бол хүн төрөлхтөнд үнэгүй хайрласан тэнгэрийн хишиг бөгөөд бие биенээ ойлгож хайрлах сэтгэлийг нь хөглөж, оюун санааг нь дэвшүүлдэг учиртай. Яруу найргийн нэгэн агшинд хөвөрч, нэгэн агшинд удаашрах хэмнэлийн ачаар яруу найрагч болон хөгжимчин хоёр дотоод сэтгэлдээ золгож, дуу хоолойгоо нийлүүлэх боломж бүрддэг. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сэтгэлд зөөлөн хирнээ эрчтэй илэрхийлэл, утга уянгын хирнээ тод томруун дүрслэлтэй шүлэг найргаар онгод нь хөглөгдсөн хөгжмийн зохиолч нар гоёмсог сайхан аялгуугаараа Түүний шүлэгт даль жигүүр ургуулж, улам өндөрт хөөргөдөг юм. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай болон Түүний хосгүй сайхан яруу найргийг эрхэмлэн таашаадаг улс улсын авьяас билэгт уран бүтээлчид халуун дулаан сэтгэлээ ийнхүү илэрхийлжээ.

Фрэд Карлин (1936-2004) бол хөгжмийн бүтээлээрээ олон шагнал, түүний дотор Оскарын болон Эмми-гийн шагналыг хүртсэн Америкийн хөгжмийн зохиолч юм. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найргаас бүрдсэн концерт дээр тоглогдсон “Энхийн эрэлчийн” хөгжимт драмын туульсын хосгүй хөгжмийг тэр туурвисан бөгөөд “Энэхүү бүтээл дээр ажиллах завшаан тохиосон нь миний хувьд туйлын их хүндэтгэл хийгээд үүний ард олон шалтгаан буй. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай яруу найрагчийнхаа хувьд, тэрээр “Бидэнд тэрхүү холбоос байхгүйн улмаас, үүнээс нь болж бид амьдралын хар бараан ертөнцтэй нүүр тулгардаг болох”-ыг янз бүрийн арга замаар дүрслэн өгүүлдэг. Хэрвээ бид дотор сэтгэлээ өнгийн харж, тэрхүү амин холбоог олж мэдрэх аваас Түүний яруу найрагт өгүүлсэнчлэн алдар нэр, эд хөрөнгө тэргүүтэн ямар ч төрлийн аз жаргалыг эрхэмлэн хайхаа болих билээ. Үүнийг л тэр чухам өгүүлдэг юм.” гэж хэлсэн буй.

Билл Конти бол Оскарын ба Эмми-гийн шагналт Америкийн хөгжмийн зохиолч юм. Тэрээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн нэгэн онцгой бүтээлийн концертын удирдаачаар ажилласан билээ. Тэрээр “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн туурвисан энэ онцгой хөгжмийг найруулж байхдаа надад бодогдсон зүйл гэвэл хөгжим шүлэг хоёуланг нь Тэр маш өвөрмөцөөр илэрхийлсэн бөгөөд сонсогчийнхоо дотоод сэтгэлийг сэргээхийг зорьсонд л энэ нууц нь оршиж байгаа юм... Хөгжим тоглогдож байхад тэр хүн, тухайн тохиолдолд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай яг л дэргэд байгаа мэт байдаг.. Хэрвээ надад Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайтай уулзах, хөөрөлдөх завшаан тохивол би Түүнд ‘Би хичнээн сайхан зүйлийг мэдэрсэн гэдгээ, Түүний бусад хүмүүст өгч буй зүйл нь хичнээн гайхалтай гэдгийг хэлэх болно.’ гэж хэлжээ.

Хөгжмийн зохиолч Rnám дуу (Ау Лак (Вьетнам) “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найраг хорвоогийн эе зохиролт хайр, эрхэм ариун оюун санааны амьдралын тухай өгүүлдэг. Харин миний бодлоор бол Түүний шүлгүүд урьдаас төсөөлсөн санааг илтгээд зогсохгүй, сац бас ‘оюун ухамсрын аялал, бодрол эргэцүүллийн их далай дахь амьдралын аян - цорын ганц өмч бол нээлттэй зүрх сэтгэл юм’ гэдгийг дүрсэлдэг. Очих эцсийн газар бол аливаа уяас хүлээснээс мултарч, гэмгүй цайлганаар гэртээ харих унаган ухаарал юм гэдгийг дүрсэлдэг.” гэж хэлжээ.

Хөгжмийн зохиолч NGUYỄN VĂN TỰ (Ау Лак(Вьетнам)) “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найрагт ая эгшиг тэрлэх боломж надад тохиосныг би амьдралынхаа хамгийн алс холын хязгаар хүртэл гараа сунгаж чадсан их зол завшаан хэмээн билэгшээж баяртай явдаг. Түүний яруу найргийн ачаар миний хөгжим цаг үргэлж мөрөөдөж байсан тэр ертөнц рүүгээ нэгэн өдөр аялан хүрэх болно гэдэгт би итгэдэг.. Би Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай найрагчийн зүрх сэтгэлд талархаж байна. Тэр бол жинхэнэ Үнэнд хүрсэн хирнээ бусдын болон бас миний ойлгож дөнгөх хүмүүнлэг сэтгэгдлийг ард олны зүрх сэтгэлд үлдээж чаддаг хүн билээ.” хэмээжээ.

Хөгжмийн зохиолч Rnám mánh s’ong (Ау Лак (Вьетнам)) “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найргийн цоморлигийг уншиж, хөхин баясах завшаан надад тохиов. Түүний яруу найраг хайр, оюун санааг хослуулан; эе зохирол, үзэмж төгс сайн сайхан шингэсэн утга санааг өөртөө оршоодог. Түүний шүлгийн мөрүүд үнэхээр өвөрмөц тансаг, чин сэтгэлийн, яруу уянгалаг байдаг бөгөөд уншигчдын сэтгэлийг хоромхон зуур хөдөлгөх увдистай. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найраг надад дээдийн дээд урам хайрлаж, Түүний бүтээлд түшиглэн хэд хэдэн дууны хөгжим зохиох боломжийг олгосон билээ. Би эдгээр хөгжмийн бүтээлүүдээ хамгаас бишрэн дээдэлдэг, олон улс дахинаа нэр алдар нь хэтийдэн цуурайлсан эрхэм хатагтай, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайд хүндэтгэлтэйгээр гардуулж байна.”

Хөгжмийн зохиолч Yū Đứс Sao Bién (Ау Лак (Вьетнам)) “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найраг олон талын зохиомжтой. Эдгээр зохиомжууд нь санаандгүй буй болчихоогүй бөгөөд маш олон эх сурвалжит шүлэг найргийг уншиж, судалж, шингээж авсан их суурь мэдлэгээс төржээ. Их Багш Чин Хай хүн төрөлхтний хувь тавилангийн төрөл бүрийн заяамал сэдвүүдийг хөндсөн байдаг. Зарим нэг нь уйт сэтгэлийг буюу зах хязгааргүй хорвоогийн уудам орчилд хаягдсан бяцхан хүмүүний туйлын ганцаардмал оюуныг илэрхийлдэг...” гэсэн буй.

Хөгжмийн зохиолч Chu Minh Kự (Ау Лак (Вьетнам)) “*‘Яруу найрагт хөгжим оршдог’* гэлцдэг. Их Багш Чин Хайн шүлгийг уншиж байхад өнгөрсөн үеийн (1975 оноос өмнөх) машид оргилуун мэдрэмжүүд буюу тэр цагийн зөн мөрөөдөл, ард олон, хөгжимд шингэсэн амьдралын дуу чимээнүүд хүртэл надад мэдрэгдсэн. Тийм учраас тэдгээр оргилуун мэдрэмжээр нэгэн цагт амьдарч байсан хүмүүс Их Багш Чин Хайн шүлгүүдийг уншихдаа Түүний шүлэг найргаас сацрах дэврүүн аясыг аялан суух нь лавтай” хэмээжээ.


Хөгжмийн зохиолч TRẦN QUANG LỘC (Ау Лак (Вьетнам)) “Би Их Багш Чин Хайн яруу найрагт бичсэн хөгжмүүдээрээ өөрийн бодол сэтгэлээ илэрхийлсэн билээ. Түүний оргилуун бөгөөд эрхэм шүлгүүд нь уран бүтээлийнх нь өнө удаан туршлагыг илтгэдэг. Түүний зарим шүлгийг хөгжмийн аязаар хөглөх дээдийн завшаан надад тохиосон бөгөөд миний аязууд Их Багш Чин Хайн шүлгүүдээр дамжин хүн бүхний урам онгодын ундаргыг сэргээх буй за хэмээн найднам” гэжээ.

Хөгжмийн зохиолч Tô Thanh Tùng (Ау Лак (Вьетнам)) “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Та надад ийм гүн гүнзгий оюун санааны мөрүүдээр хэлхэгдсэн оргилуун сайхан шүлгүүдийг бэлэглэсэнд тань баярлалаа. Сайн яруу найраг угаасаа л арвин их сэтгэгдлийг хүнд төрүүлдэг бөгөөд утга нь гүн, агуулга хийгээд бүтэц нь тодорхой байдаг юм. Хөгжим шүлэгт даль жигүүр нэмдэг ч энэ тохиолдолд Түүний шүлгүүд миний аязуудыг аван дүүлж байгаа нь илт ээ... Их Багш Чин Хайн өөр олон шүлэгт ая хийх их завшаан ирээдүйд над тохиох буй за хэмээн найдна.” гэжээ.

Хөгжмийн зохиолч Kim Tuán (Ау Лак (Вьетнам)) “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найраг түгээмэл биш нэн хүчирхэг хэв маягаар сэтгэлгээний шинэ хэлбэр янзыг илтгэн туурвижээ. Найрагчийн сэтгэл санаа аугаа бөгөөд гуйвшгүй зорилгод чиглэсэн хайраар дүүрэн, хосгүй их дотоод хүчийг эгшээн буйн баталгаа энэ буюу. Шүлгийн мөрүүд уншигчийн сэтгэлд намуухнаар нэвтэрч, онцгой тансаг гоо үзэгсэлэнд оюун бодлыг хөрвүүлнэ. Миний бодлоор, Түүний шүлгийн зохиомж хийгээд илэрхийлэл нь Барууны зохиолчдын дунд байдаг ч Ау Лак шүлэгт ховорхон тохиолддог үзэгдэл юм. Шүлэг юунд нь ая зохиож суухдаа би Бүтээгчийг нь аргагүй биширч, хүндэлсэн билээ” хэмээв.

Профессор Chang Kuang-Bin (Формоса (Тайвань)). Формосагийн үндэсний эрдэнэс болсон авьяас билигтэн, профессор Chang Kuang-Bin бүх амьдралаа Хятадын калиграф (уран бичлэг) болон уран зургийн урлагт өргөж, залуу уран бүтээлчдийн авьяас билгийг нээн хөгжүүлэхэд зориулж иржээ. Тэр олон эрхэм шагнал хүртсэний дотор Үндэсний Соёлын Нийгэмлэгээс олгосон Хятадын Соёлын өвд үнэтэй хувь нэмэр оруулсны шагнал, Тайваний төр засгаас олгосон Соёлын Шагнал зүй ёсоор багтдаг юм. Профессор Chang 96 насандаа Хятадын уран зураг, калиграф, урлагийн түүхийн чиглэлээр амжилтынхаа оргилд хүрсэн билээ. Амьдралд амар амгалан, нээлттэй сэтгэлгээгээр ханддаг профессор Chang амьдралыг үзэх үзлээ уран бүтээлүүддээ нэвт шингээсэн байдаг.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн “*Эрин Зууны Хайр*” цоморлиг профессор Chang-ийн сэтгэлийг гүнээ хөдөлгөжээ. Тэрээр Чин Хай Багшийн орчлон хорвоо, амьдралын мөн чанарын тухай сэтгэлийн илэрхийлэл буюу шүлгүүдэд нь тусгагдсан гариг ертөнцийн тулд, хамаг амьтны төлөөх хайр энэрлээ улам тэтгэн хөгжүүлээсэй хэмээсэн залбирлыг нь дэмжин хуваалцаж буйгаа өгүүлсэн билээ. Профессор Chang “*Эрин Зууны Хайр*” яруу найргийн цоморлиг хэвлэгдсэн баярыг мялааж нэгэн бадаг шүлгийг сонгон авч гоёмсог Хятад уран бичгээр бичиж өгсөн билээ.



Профессор Chang Kuang-Bin -ий бичсэн хятад калиграф

Үзэсгэлэнтэй сайхан урлаг бидний мөн чанарыг сэрээж, хайрын сэтгэлийг урамшуулдаг болохоор бид профессор Chang Kuang-Bin-д Хятадын өв соёл, урлагт том хувь нэмэр оруулж байгаад нь талархан ёсолж байна.

ПРОФЕССОР CHIANG I-HAN, Формоса (Тайвань). Улс үндэстэндээ хүндлэгдсэн профессор Chiang I-Han бол Хятадын орчин үеийн бэхэн уран зураг ба калиграфын алдартай уран бүтээлч билээ. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн “*Эрин Зууны Хайр*” цоморлиг удахгүй хэвлэгдэх гэж буйг дуулаад тэрээр номны Хятад хэл дээрхи хавтасны бичээсийг тусгайлан бичиж баяр талархлаа дамжуулсан юм.

Профессор Chiang олон төрлийн урлагт хүч сорьдог. Орчин цагийн Барууны урлагийн ухагдахуунуудыг Хятадын уламжлалт соёлд шингээхийг зорьсон түүний уран бүтээл

Эрин Зууны Хайр


Чамайгаан би олов!

*Сүнс минь сар болон оддоор чимэгдэн
Хатаж гундсан зүрх хайр цацруулан сэргэв.
Аяа, орчлон хорвоо минь!*

*Зуун зууны хайр минь энд л одоо тохиов.
Чи минь айлсан ирж, түм буман ертөнцийг
дэвшүүлэв.*

Чин сэтгэлийн долгис хаа холын эрхист хүрэв.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн шүлэг
Chang Kuang-Bin (96 настай) Лисхан дахь гэртээ урлав.
2010 оны Зун



Профессор Chian I-Han-ы хятад уран бичлэг

Хэдийгээр нас сүүдэр 85 хүрсэн ч профессор Chiang “эрх чөлөөг хязгаарлагч хуучинсаг тулгалтуудыг эвдэх, хуучирсан үзэл бодлоос чөлөөлөгдөх... залуу үед амьдралыг ухааруулж, төрөлх зөн билгийг буцаан дуудах” үйлстээ өөрийгөө тасралтгүй зориулах урам зориг дүүрэн явна. “Ногоон уул” хэмээх түүний зурсан гарын үсэг идэрхэн сэтгэлийнх нь илрэл болдог юм. Газар дэлхийд үзэсгэлэн гоог авчрах, хүн төрөлхтний ухамсрыг бадраан дэвжээх утгыг илэрхийлсэн уран бүтээлүүд туурвисанд нь профессор Chiang гуайд бид талархан ёсолж байна.

Wu Sheng, (Формоса (Тайвань)) бол эх нутгаа магтан дуулсан яруу найргаараа алдаршсан нэгэн. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найргийг уншаад тэр “Хайрын тухай санаа бодлууд хүний хувийн туршлагаар баяжихаараа улам жавхлан төгөлдөр болдог юм байна” хэмээн элэгсгээр өгүүлсэн бөлгөө.

Хятадын сонгодог болон Барууны романтик дүрслэлийн аль алиныг илтгэсэн өвөрмөц хэв маягтай.

5 дугаар Алтан жилийн (2008) 12 дугаар сард Формоса (Тайвань) дахь Шиху төв дээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн “Тэнгэрийн урлаг” шинэ номын албан ёсны нээлт болох үеэр профессор Chiang өөрийн биеэр оролцсон юм. Тэрээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн эрхэм дээд үзэл бодолтой санал нийлдэг төдийгүй урлагийн бүтээлүүдийг нь ихэд биширдэг.

Lin Wu Hsien (Формоса (Тайвань)), Хятад ба Англи хэл дээрхи зэрэгцүүлсэн яруу найраг, гар зургийн *Хязгааргүй Тэнгэр чуулбарын* зохиогч тэрбээр “Яруу найраг бол Сүнсний гэжээл нь юм! Яруу найрагч Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай яруу найргаараа бидний сүнсний цонхыг гэрэлтүүлж, зүрх сэтгэл ба сүнсний маань анхдагч цэвэр тунгалаг төлвийг сэргээж өглөө. Бүтээгчийн бүтээсэн хамаг төрөлтнүүд угтаа нэгдмэл гэдгийг бидэнд сануулсан учраас бид уул ус, ой хөвч, далай тэнгис, ан амьтдаа хайрлан хамгаалах үүрэгтэй гэдгээ улам гүнзгий ойлгов. ‘Амар амгаланг зүрх сэтгэлдээ оршоохын тулд хамтаараа энэ гаригаа засаж ээлбэн, Дэлхийгээ Дивжаажин болгоё!’ Яруу найргийн сайханд баясацгаая!” гэж хэлсэн билээ.

Lin Hsu Wen Er (Формоса (Тайвань)), Персиммон Калчер хэвлэлийн компанийн ерөнхий редактор тэрбээр “Бидний сэтгэлийг юу хөдөлгөв гэхээр үгийн сайхан биш, харин үгнээс мэдэрсэн гэгээрсэн билэг ухаан, хамаг төрөлтөнд дэвшүүлсэн нигүүлсэл, үнэнч сэтгэл юм. Эдгээр яруу найргийг уншсан бид л энэ гайхамшигт чанаруудыг мэдэрсэн.” хэмээжээ.

Tang Mei-Yun (Формоса (Тайвань)), Тайванийн Tang Mei-Yun Дуурийн компанийн Ерөнхийлөгч бөгөөд Тайваны ардын дуурийн алдарт дуучин тэрбээр:

“Өдгөө цагийн нийгэм дэх бухимдал, олон гэр бүлийн зовлон шаналал магадгүй хүмүүсийн ухамсар, ухаан санаа зөв зохистой төлөвт байж чадахгүй байгаагаас болдог байх” хэмээн өгүүлсэн юм. Мөн Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн “*Эрин Зууны Хайр*” яруу найргийн шинэ цоморлигийн тухайд “Хэрвээ хүн бүр энэ номыг уншдагсан бол тэдний ааш зан, хувийн чанарт зохих сайжрал гарна даа” хэмээн тэмдэглэжээ.

Хатагтай Tang түүнчлэн “Энэ ном сэтгэл хөдлөл ба мэдрэмжийг их олон өнцгөөс хөндсөн байгааг, ялангуяа одоо ургамлаар хооллох явдлыг өргөн хүрээнд ярих болсон нь хамаг төрөлтөнг хайрлах сэтгэлийн илэрхийлэл юм” хэмээн нэмж хэлсэн байна. “Ургамлаар хооллох нь энэрэнгүй сэтгэлээ хөгжүүлэхэд бидэнд тустай. Хамаг амьтанд энэрэл нигүүлсэлтэй харьцахад бэлэн байгаа тэр хүний хийсэн үйлс бүхэн хүмүүсийн сэтгэлийг

хөндөх нь гарцаагүй. Миний бодлоор энэ амгалан байдал, энэ унаган мэдрэмж, энэ өгөөмөр сэтгэл л бидний нийгэмд дутагдаад байгаа юм. Тиймээс энэ ном бол яалт ч үгүй хүн бүрт уншаарай гэж захиуштай ном мөн.” гэжээ.

Kang Yuan Формоса (Тайвань) бол төрөлх нутгаа туйлаас хайрлаж, амьтан ургамлыг нь анхааран халамжлагч нэгэн билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найргийг уншаад төрсөн сэтгэгдлээ ийнхүү хуваалцжээ:

Аялгуут хөгжим сүнсийг уугуул чанарт нь дэвшүүлэх адил

Алаг бараан хорвоог энэ л шүлгүүд ариусгана.

Адын хүсэл шунал ашид одоо арилна,

Анхдагч мөн чанар үйлийн барилдлагаар сэргэнэ.



ТЭРГҮҮН ХЭСЭГ

Залуу Нас,
Төрөлх Нутгаа Хайрлах Хайр



Тэр Минь

(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн залуу насандаа бичсэн шүлэг)

Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Nhà Tôi"

Унаган багын гэр минь уулын энгэрт билээ.
Уяхан салхи, урьхан үүлс хурмастын энгээр билээ.
Алагхан цэцэгс, ногоохон өвс агаартаа анхилнам билээ.
Аяа, нарсан ой саран авхайд найган бүжнэм билээ.

Үнэр ялдам цэцэрлэгт үзэмж тансаг эрвээхэй наадна.
Ягаан, шар, хүрэн, улбар, хөх, улаанаар өнгө хуарлан эрээлж,
Үзтэл туяхан ишнээ өнгийн цэцэгс дэлбээлнэ.
Ямархан анхил үнэр Диваажин өөд хөтөлнө вэ!

Уулсын ногоон оройг саран гийгүүлэн мэлтийж,
Уужим саруул агаарт энхжингийн дуу цуурайлна.
Урин салхины аясаар алтан аялгуу түгэж,
Уудам цэлмэг тэнгэрт энх амгалан дуурьсана.

Ой хээрийн жим халуун дотноор угтаж,
Аян замыг тань ерөөн, мөрөөдөл юугий тань түшнэ.
Олон бээрийн тэртээ тэнгис далай яруухнаар
Алс хэтийг дуудан миний л хамт дуулна.

Хавартаа анхилуун цэцэгс уул талаар алаглана.
Зундаа амтат мөрөөдөлд умбан голио царцаа царгина.
Намартаа шаргал навчис цонх хээлэн шаргина.
Өвөлдөө халуун галын дөл омог төгөлдөр цоролзоно.

Эргэх дөрвөн улиралд зүрхэнд минь цэцэг дэлбээлнэ,
Энэ дэлхийн хаа ч очсон үүлс хөвсөлзөн мэндэлнэ,
Анд олон нөхөд зүрх сэтгэлийг хөгжөөн тэтгэнэ,
Амьтад болон шувууд дотны найзууд мэт ижилсэнэ!

Хавирган сар мэт пийпаа хөгжмийг тоглонхон
Халуун сайхан аялгуу юугаа эгшиглүүлнэ.
Хайрын дуунд сэтгэл хөхин баясч,
Хайлган зүрх хөгжмийн хэмээр хөглөгдөнө.

Тра ла ла фа ла
Фа ла ла тра ла
Тра ла ла фа ла
Фа ла ла тра ла.

Санаанд Улхэн Зун

(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн залуу насандаа бичсэн шүлэг)

Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Hạ Nhỏ"

Тээр жилийн зуны эхэн сарыг чи санана уу?
Нэл улаан цэцэгтэй эрхэмсэг мод тэнгэрт цойлж,
Тэрхэн чиний залуу насыг санагдуулдаг сан.
Нэг ангийнхнаасаа салан одох юутай гунигтай!

Баяр хөөртэй ч сална гэхээс сэтгэл нэг л гуниглуун,
Бие биесийнхээ үсийг хайрын ягахан цэцгээр чимнэ!
Салахын тоостой мөр зуун өдөр дагана,
Санахын гунигтай айлсаж, царцаа нэгтэй царгина.




Өгөөмөр их тал, номин цэнхэр усаа зориход
Өргөн гол мөрөн эртний танилаа мяралзан угтав.
Шуугин цэлэлзэх усыг завь хөлөглөн туулж,
Шуулж ургасан тосгон руу ижийдээ би очив.

Ахын хөлөг онгоц цэнхэр далай, шаргал говийг гатлахуй
Анхилхан уд мод намс намс найгаж, намуун аялгуу эгшиглүүлнэ.
Эгчийн машин харин өгсүүр өөд замнахуй
Эгнээ уулнаа туссан үүлсийн сүүдэр инээмсэрснэ...

Салхи хүүгэж, тоос боссон хотдоо би үлдэж,
Зуны наран жаргахыг харуулдан, гандаж буй цэцэгсийг тоолно.
Зуун өдөр өнгөрч, халуун дотно тэврэлтийг мөрөөсч,
Сургуулийн саравчнаа олуул хөгжилдөх мөчийг хүлээнэ.

Хонгор минь, баясал дүүрэн өдрүүдээ, анд сайн найзуудаа,
Хүндэт багш нараа, нандин холбоогоо мартуузай.

Зүйлийн улаан цэцэгс салхиар нэг эргэлдэн
Зүрх сэтгэлд минь сар өдрүүдийн уртад чимээгүйхэн унана...
Сургуулийн эзгүй хашаа мэт сэтгэл минь нэг л ханхай,
Гуниг дүүрэн зуун өдөр зуун жил мэт урт аа!





Яруу найрагч нөхөртэйгээ хамт амьдарч байсан үеийн зураг
1980 оны эхээр, Герман, Мюнхен

Тэр л Өдөр

*(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн залуу насандаа
бичсэн шүлэг)*

Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Một Ngày"

Тэр нэгэн өдөр хичээлийн чөлөө тааруулж,
Төрөлх тосгоноо зорин аавыгаа даган хөдөллөө.
Танил хуучин автобус замаа хөөн гэлдэрч,
Тал хөндий, далан шуудуу эрээлэн өнгөрлөө.

Замын турш тариа будаа ханхийн үнэртэж,
Бадран гийх нарны алтан цацраг туяарна.
Задгай талбайд алим жимс алаглан ургаж,
Байр сууцны улаан дээвэр тунаран үзэгдэнэ.


Анхилам зуны салхинд сүүл хийсгэж,
Алаг нохой автобус даган шогшино.
Ал улаан тоос замаар нэг манарч,
Алс тэртээд хулсан ой бүүдийнэ...

Нас бие гүйцсэн одос үхрийн сүрэг
Нарийн зам ширтэн эрэгцэн зогсох нь гайхангуй.
Өгөөмөр цэлгэр талаар харц бэлчээн өнгөрөх
Өрөвтасын сүрэг нисэн одох нь амирлангуй.

Хадаж овоолсон өвсийг чирэхээр
Хоёр үхэр тэнхээ мэдэн зүтгэлнэ.
Хүнд ачаатай тэргээ угзарсаар
Хором мөчийг алгуурхан хорооно.

Мөнгөлөг уулын хяраар өнгөрөхөд
Өнгөлөг цэцэгсийн хүрээлэн үзэмж гайхуулна.
Мянган зүйлийн цэцэгс өнгө хуарлан тунарахад
Өнийн салхинд үнэр анхилан алаглана!

Хөлгийн тавцангаа орхин буухад
Хөлгүй давалгаа эргээ халин цалгина.
Уран дэлбээт сараана сэлүүр зөөлөн илбэхэд
Усны болцруут цэцэгс үүгээр түүгээр хөвнө...



Ширхийтэл тоормослож, автобус зогсох бүрийд
Шинэхэн гадил, бэрсүүт жүрж,
Чихэр өвсөнд ороосон амтаг жимс тэргүүтнийг
Чимээ хадаан худалдаачид наймаалж гарна!

Хуурсан самар, жигнэсэн эрдэнэ шиш,
Хайрсан жигнэмэг, будааны бялуу,
Наргил модны самар, чихрийн нишингийн шүүс,
Найртай нутгийн минь үнэрийг янз
тансаг болгоно!

Тэн даах идэр эрс
Тэнхээт мөрөөрөө ачаа зөөнө.
Найрсаг гийчид эргэн тойрон
Найр хурим шиг бужигнана.


* * *

Зорчигч олон бахтай чангаар хөөрөлдөнө,
Зорьсон газраа автобус тэмцэн хурдална.
Гэнэт тэнгэр хөмөрч, газар өндөлзөх шиг болов,
Гэнэгүй олон хүмүүс тэрий хадан унав!

Аз нүүрээ буруулан автобус дэлбэ үсэрч,
Эз нүүрлэсэн жолоочийн толгой нь тасар татагдав.
Хөөрхий нэгэн зорчигчийн бие цогцос нь үгүйрч,
Хөл нь биеэсээ салж, гүүрний тэртээ хөсөр унав!

Бие давхар нэгэн эмэгтэй
Цусан шалбаагт амь тэмцэн энэлэв.
Гэмгүй балчир хоёр хүү
Гүнзгий голд живэн живсээр далдрав!

Сав суулгаа гартаа атгасан
Үсэн буурал өтөл настны
Сүнс нь хаашаа одсоныг ч
Үнэндээ хэн мэдэх сэн?!...

Амьд үлдсэн гурван хүний хамт 
Аав минь шархаа даран гэлдэрч,
Аяны замаа даган урагшлахад
Асгарах цус нь дусал дуслаар урсана!...

Тэр л Нэгэн Өдөр

*(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн залуу насандаа
бичсэн шүлэг)*

Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Và Một Ngày"

Бяцхан томоогүй цагийн хэрж хэссэн ой,
Балчир ахуй үеийн сэлж өссөн гол,
Бага хүүхэд насны бүгэж явсан урцаа эргэхээр
Би нэгэн өдөр уулын царамнаа гарлаа.

Тосгон даяараа дүрвэн нүүсэн
Аймшигт дайны үе сэн.
Танхил охидоо харж хамгаалан
Аав ээжүүд талбайд ажилладаг сан.
Тэсрэх бөмбөг, тэнэсэн сумнаас
Аглаг уулын сүрлэн урц л халхалдаг сан.

Шуулж, өвсхөнөөр гол зогоож,
Аяга хүрэхгүй будаагаар амь тээдэг сэн.
Шөнөжин тэсгим агаар хүйт дааж,
Айдас нэмж ирвэс, барс эргэлддэг сэн!

Цайвар саран тэртээгээс гийгүүлж,
Цахирмаа цэцэг энэтээгээс үнэртдэг сэн.
Амар амгалан тэртээх өдрүүд шиг
Азарган тахиа эртлэн донгоддог сон!

Энд л би анд олон найзынхаа хамт
Аагим зуны нарнаас үе үехэн хорогддог сон.
Энд л бид ногоохон мөчирсийн доор
Амттайхан төмсөө эн тэнцүү хуваадаг сан.

Танхи бага нас минь өнөө улиран одож,
Төрөлх нутаг усанд минь энх тайван тогтножээ.
Тэгэвч бидний нөхөрлөл алсын алсад анирлаж,
Таавар оньсогын гол, барилдлага юугий
минь зааглажээ.

Энхэр бага насаа дурсаад
Энэ л өдөр уулнаа гарлаа.
Дайны дурсамж хүүрнэн найгах
Тэр л уулын моддыг ширтлээ!

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн уран зураг “Арга Билгийн Тулаан”

(1995 он, Формоса, Шиху Төв)

Энэ зураг дээр хоёр эрэгтэй хүн хуурмаг хорвоогийн цалманд буй хүмүүн чанарын Арга ба Билгийн хүчний этгээд дүрд тоглон байх ажээ. Тиймээс тэд эерэг сөрөг, бодит хуурамч талуудын халз тулаанд амь өрсөн орооцолдож орхиж. Тулаанд улайрсаар тэд өөр хоорондын ялгаагаа эвсүүлэн найрсаж, хамтын хүчээр эргэн тойрон шатаж буй галаар дүрслэгдсэн эгэл хорвоогоос зайлж чадна гэдгээ ухаарсангүй. Хүйтэн хөндий эмэгтэй (Чөтгөрийн хааны зэвсэг) их л ёжлонгүй, “Та нар миний хяналтанд байна. Та нараар наадья гэсэн ч хорвоогийн бүхий л цаг хугацаа миний гарт байна. Яарах хэрэг юун. Яаралгүй наад галдаа аажуухан шарагд! Энэ зовлонд зугуухан баяс!” гэж хэлэхийг тэд анзаарах сөхөөгүй харагдана. (Жич: Их Багшийн зурсан зургийн цаадах дэвсгэр дээр намдуу бүүдгэр бөгөөд маш удаанаар дүрэлзэж буй гал дүрслэгджээ.)

Энэхүү зураг хачин бодитой мэт санагдах энэ хуурмаг хорвоод татагдахгүй байхыг бидэнд сануулдаг. Төгс Гэгээрсэн Их Багшийн замчлал дор оюун санааны бясалгалыг дадуулах нь эгэл харанхуй хорвоогийн чанад хүрч, эрхэм үүрдийн Үнэнг олох цор ганц арга зам мөн бөлгөө.





Яруу найрагчийн авсан
гэрэл зураг



❧ ДЭД ХЭСЭГ ❧

Хамал амьтныг хайрлах Хайр

Төлөгний Үг

(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 20 орчим настайдаа бичсэн шүлэг)

Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Lời Chúc Vẹn"

Би бол зүгээр л нэг балчирхан гөлөг,
Миний сэтгэл гэвч хайраар бялхан байна.
Би бүхий л амьдрал, үнэн хүслээрээ
Манаж таныгаа хамгаалахад бэлээн.

Эгэлхэн амьдралыг минь тэтгэсэн
Өгөөмөр сэтгэлд тань баярлалаа.
Идэж уухаар дутаалгүй өсгөсөн
Үнэн санаанд тань гялайлаа.

Амьдралын шүтээн, авралт багш минь болж,
Алдрай зүрхэнд минь та л ганцаар оршино.
Өдөр болгон таныгаа хаалганы дэргэд хүлээж,
Шөнө бүхэн тайван нойрсохыг нь харуулдана.

Сэтгэл минь тань руу үргэлж тэмүүлнэ,
Нүд минь тань руу үүрд ширтэнэ.
Гар тань юутай зөөлөн, юутай аятай,
Амьтан биднийг илбэн гийх нь юутай азтай!

Тандаа хайртайгаа би хэрхэн ойлгуулах билээ!
Таныхаа эзгүй үед би хөсөр орхигдсон мэт ээ.
Таныгаа би мөнхийн хайраар хайрладаг билээ,
Таныхаа орон гэрт би хорвоог орхих биз ээ.
Төгсгөл ирэвч би жаргалтай инээмсэглэх билээ.

Тандаа хичнээн их хайртайн баталгаа нь тэр ээ!



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
өөрөө анагааж эдгээсэн Лаки нохойны хамт.
2005 оны 9-р сар, Франц Боржус

Шувууны үг

(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн

20 орчим настайдаа бичсэн шүлэг)

Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Lời Gà Mái"

Өглөө босоод би хөндий талыг зорино,
Өндийж зогсоод уул устайгаа мэндэлнэ.
Цайлган гэнэн дэгдээхэйнүүдээ дагуулан
Цөөрмийн усанд умбан шумбана.

Ээжийнхээ араас дэгэн дэгсээр
Шижир өнгийн балчир сөдөө дэрвүүлэх
Энхэр үрсийн минь эрэвгэр нүд
Шошийн үр мэт юутай хөөрхөн!

Эрдэнэ шиш, үр тариа өгсөн хүмүүн ямар ачтай!
Эргэх хоногийн урсгалд бидэн санаа амар, азтай.
Тунгалагхан ус, тунсагхан модод,
Тун ногоохон өвс сэвшээ салхинаа аятай.

Тэнгэр хөхөрч, үүлс хөвөрч,
горхи урсана л...

Аяа, амьдрал гэгч мөрөөдлийн үлгэр мэт ээ.
Тандаа талархая, Бүтээгч Бурхан минь,
Амар амгалан өдрүүдийг бидэнд заяасанд чинь.

Гамшиг гэтэл дайрч, гай гэнэт ирэв.
Тоос хадаан үймж, тор дээрээс нөмрөв.
Ган хутганы ир гялс хийн үзэгдэж,
Түнэр улаан цус чимээ анирлан урсав.

Энэлж үлдсэн үрсээ гэхээс
Эхийн нь сэтгэл эмтэрч байна.
Наминчлан гуйя...

үрсийг минь... хайрлаач...
Намайг яах вэ...
тэднийг минь... энэрээч!

Яруу найрагч 14 настайдаа,
үеэл дүүгийнхээ хамт.
Ау Лак, Бонг Сон



Тсооройн Цэ

(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 20 орчим
настайдаа бичсэн шүлэг)


Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Lời Lạ Sơn"

Алтан дэлхийд төрөх өдөр минь ирж,
Анхлан тантай учран тохиож билээ.
Ягаахан зүстэй, мариалаг бөөрөнхий амьтан
Ямархан баясалтай эхтэйгээ тоглон байлаа.

Өхөөрдсөн харцаа над дээр унаган
Эгдүүтэй хөөрхнийг минь та гайхдаг сан.
Өдөр болгон намайг эргэн тойрч
Элдэв ногоон зууш, амтат ууш авчирдаг сан.

Эрдэнэсээс илүү элбэрэл юу тэнь үнэтэй.
Ээж бид хоёрын зүрх сэтгэл уяралтай.
Таны хайр халамж, нөмөр нөөлгөн дор
Тайван сайхан амьдралаар өсч би торнисон.
Өдөр өнгөрөх бүрий мах мариа нэмж,
Өнгийж идэн, өндийж наадан эрхэлсэн...





Тэр нэгэн өглөө тийм л сайхан байлаа,
Тэнгэрийн хаяа цэлийн үүлс урьхан хөвнө.
Эхийнхээ дэргэд тухлан таатайхан хэвтэж билээ,
Эмгэнэлт явдал болохыг яахин бид мэднэ.

Барс, заан мэт бяралхуу
Булчинлаг хоёр залуу
Бултан зайлахын зуургүй
Бяцхан биеий минь ааглан
Барин авч торонд хийв!
Бурхан минь, яах нь энэв?

Ачилж хараач, ээж минь,
Аварч хамгаалаач, эзэн минь.
Алдрай балчир намайг орхиоч гэж
Айдаст автан би чарлав!

Хөөрхий ээж минь уйлан хайлахуй
Харах нүдий нь цөхрөлийн нулимс бүрхэв.
Харуусал нөмөрсөн сэтгэлийн уй гашууг
Хурмаст тэнгэрт ч агуулж яахин чадавав!

Миний эзэн цааш харан
Мөнгө тоолоод гар нь завгүй.
Мэлмэрэх нулимс зүрх зүсэн
Машины бүхээгт сэтгэл цөхрөнгүй.

Шинэ хүнийхээ баярыг тэмдэглэж,
Ширээгээ тооройн мах чимэглэнэ.
Хонуулаад тэрнийг нядална гэж
Хоёр залуу хоорондоо хөөрөлдөнө.

Ээ халаг, энэ амьдрал яасан ч их тоглоомтой юм бэ,
Сүнс минь эцэж туйлдав.
Зүрхэнд минь нулимс хурж,
Цус минь горхи мэт урсана.

Энэ л амьдрал юутай хяслантай,
Эгэл сүнс ямархан гаслантай.
Элэг зүрхэнд нулимс хураастай,
Энэлэн горхилж, цус урсаастай.

Төрөхөөс минь эхлэн тэжээсэн болохоор
Таныг надад хайртай гэж бодсон сон.
Тэгэвч тэр бүхэн худал байсан юм уу?
Таны хувьд би олз ашиг төдийхөн гэж үү!

Баяр найрын үеэр хүмүүсийг хөгжөөж,
Баясан цэнгэхийн бахыг нь хангахын тулд
Биеийг минь таллан, ясыг минь мөчилнө.
Махыг минь хуваан, таваглаж өрнө.

Таны энхрийхэн үр хүүхдийг
Минийх шиг тавилан бүү дайраг.
Тайван амгалан, урт удаан насалж,
Мэнд амгалан цугтаа найрстугай...

Энэ л гэр бүлийнхэн ариун сэтгэлээр амьдарч,
Эргэх олон төрөлдөө хүмүүн болон мэндлээсэй.
Хувь л тавилангийн эрхээр үйлийн үр тохиож,
Хэзээ ч гахай л болон бүү төрөөсэй!

Аяа хөөрхий, амьдрал минь баяртай...
Ард үлдсэн ээж минь тарчлана гэхээс уйтай.
Энэлэн яах вэ, нулимстай даваагаа би давна...
Ээж минь дээ... ээж минь!

Төсөөлөөд нэг бодоч!

Өчүүхэн жижиг, хог шороогоор дүүрэн саванд хоригдном,
Өгүүлэн жишиж хэлэхийн арга алга даа, энэ л газрыг.
Өндрийн наран, намуун салхин үс ноосонд минь хүртээлгүй
Өмхий самхай үнэр, шээс шинхэгэн дунд амьдарнам, би!
Энэ бүхэн хүмүүний тааллаар л юм гэж үү?

Эргэж хөрвөөхийн ч тэнхэлгүй болтол минь
Элдвийн эм тангаар шахаж бордох юм, намайг!
Энд үд дунд бүгчим халуун, үдэш орой тэсгим хүйтэн байнам.
Эрүүл агаар хаана вэ? Энэ амьдралыг юу ч гэмээр юм бэ дээ?

Хүүхдээ яалтай билээ? Тэднийг минь та гишгэчиж орхих биз!
Хөөрхийс маань хүйт хийгээд бохиросоос үхэж үрэгдэнэ.
Хэрвээ тэд үлдэж гэмээнэ хариугүй бага насандаа
Хаа холдох вэ, идүүлэх л биз! Аяа, Бурхан минь, аварч өршөө!!!

Хар дарсан зүүдээ би хэлж ярьж чадахгүй нь,
Хүмүүн төрөлтөн олон ч хайрлаж энэрдэг нь хэн сэн!?
Хүмүүсийг цагтахын төлөө халуун цусаа урсгасаар
Хачин түгшүүрт, зовлонт амьдралаар би амьдарнам.

Мөч мөчөөрөө тасчуулан, хана, таазнаас өлгөгдөж,
Машины бүхээгт мах болон санжиганадаг аа, бид!
Өмөлзөн гуйж, шаналсандаа дуу хадаан хэвтэхэд чинь
Өөдгүй муу алуурчин хоолойг чинь огтлон
Өнгөт хүрэн цусыг чинь гожгодуулбал яана вэ, хүн та!

Ийм байдлыг хэн тэсч, инээн баясч хэрхэн чадах вэ?
Ийм байтал зүгээр явж, хэлгүй, дүлий, сохор мэт байх уу?
Хүмүүн олон догшин хэрцгий болсноос хойш,
Хайр энэрэл, төрөлх чанараа гээснээс инагш
Хэвийн мэт болчих нь энэ үү, ийм л аймшигт үйлдэл?

Хүмүүн та нар биднийг өшигчинө, хутгална, зүснэ, тарчлаана,
Хүлцэл тэвчээрийн хязгаараас өвчин шаналан давна!
Хайлан уйлнам, туслаач!... Хэн нэг нь гараа сунгаач!?...
Хачин давчуу, харуй бүрүй, аймшигт ханан дунд
Халуун цус хаа сайгүй урсана, хальж нэлийнэ.
Харсаар байтал энэ бүхнийг зогсоон, харанхуйг тонилгох
Хэн ч алгаа, аймшигтай юм, аюумшигтай юм.
Харин би хүчин мөхөстөж, дагжин чичирч байна.

Хэрвээ та там гэж юу байдгийг мэдэхгүй бол
Хүрч ирээд хар, өөр хаа ч биш, тэр чинь энд л байна!
Хүмүүн андууд минь ээ, үүнийг яанам бэ?
Хөөрхий намайг тарчлааж, идэхийн учир юунд вэ?

Та болон танай гэр бүлийн хэн нэг нь
Тэр аймшгийг үйлдэж байна хэмээн
Төсөөлөөд нэг бодооч!



Их Багш Чин Хайн зурсан зураг
“Хаврын инээмсэглэл”
2007-2008, Монако

ГУТГААР ХЭСЭГ

Цэцэг Хураана, Эрдэнэ Зайн
Амгурсан Хайр

Эрин Зууны Хайр

Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Người Tình Thiên Cổ"

Энэ л шөнө би гэрэлт оддын доор амсхийн
Энгүй холын гариг өөд бодлоороо аялнам.
Орон зай, цаг хугацаа бидний хайрыг гандаахгүй ч
Орь зүрх минь зуун зууны аясаар хатаж гундана.

Үйл дагах нүүдлийн альхан талд нь явна вэ?
Үй олон эрхэсийг нэгжин чамайгаан би хайлаа.
Үймсэн түмэн ертөнцөөр хөл эцээн аяллаа.
Үүнийг чи харин тааж мэдэхсэн билүү?

Зүрх сэтгэл юүг минь зөнд нь ганцаар үлдээж,
Зөндөө холын ертөнц рүү үүлс даган аялж,
Сансар огторгуй даяар хайраа чи түгээснээ
Санахгүй л байна гэж үү, хаа холын амраг минь?

Хайрт чамтайгаа эргээд нэгдэхсэн гэхдээ
Хамаг орчлонгийн даяар дайдад би аялсан.
Мянга мянган жил болсон ч цөхрөл үгүй хүлээх
Миний үнэнч сэтгэл мэт цаг хугацаа хүлцэнгүй!

Хөхрөх усан мэт мэлмий баясгасан дурсамж
Сүнсийг минь дэвшүүлэн тэтгэгч гэрэлт оддын адил.
Жаргах нарны туяанд үүлс алтрах мэт үсэн шаргалтаж,
Эрт цагийн халуун хайрыг мөрөөдлөөр сүлжинэ л!

Эрхэм төрх чинь гэрэлтэхэд тэсгим жавар уясаж,
Энхэр хөл чинь хүрэхэд хайрга чулуу уярна.
Ялдам гэгээн инээмсэглэлд хаврын цэцэг дэлгэрч,
Янаг хонгор дуунд үдшийн шувууд тайтгарна.

Алхаад өнгөрөхийн төдийд уулс өндөлзөж,
модод найган баясна.

Номин хөх тэнгэрт маргад ногоон өвс
үүлсийн хамт бүжнэ.

Аяа, байгаль юутай үзэсгэлэн төгөлдөр!
Ой хөвч, гол мөрөн аялгуулан дуурьсахуй
Мянга мянган улирал солигдож,
саран тэртээд мэлмэрнэ.

Орь зүрхэн тэтгэж,
Чин сэтгэл мөнхөд оршино...

Чамайг би өнөд дурсана.

Газар дэлхий өнгө тунамал гийхийн учир
Ганган цэцгэн титмээр гайхуулж би гоёно!

Чамайгаан би олов! Сүнс минь сар болон
оддоор чимэгдэн
Хатаж гундсан зүрх хайр сацруулан сэргэв.
Аяа, орчлон хорвоо минь!
Зуун зууны хайр минь энд л одоо тохиов.
Чи минь айлсан ирж, түм буман
ертөнцийг дэвшүүлэв.
Чин сэтгэлийн долгис хаа холын эрхист хүрэв.

Тийн атал тэртээх одод нүдний
буланд ажин түжин,
Чи бидэн хоёр танил хэдий ч хүйтэн хөндий,
Чилийсэн уртын замд бидний сэтгэл холдоо юу?

Бидний амьдарч асан билгүүн алс гаригийн
Биесээ түшин суусан бороотой үдшийг санана уу?
Хайлган хайр гэнэт сэтгэлээс урван холдов уу!
Хүйтэн хайрга гэтэл далайд урсан одов уу.

Амьддаа бид ахин учрах уу, аль эсвэл олон
галавын дараа юу?
Асуулт дүүрэн харцаар салахын цагтаа ширтэнэ.

Өдөр шөнөөр солигдож, дэр нулимсанд норно.
Өнгөлөг саран, өндрийн одод бүүдийж,
үүлс гунигтай хөвнө.

Тэсгэл үгүй шаналлыг чи минь
олж мэднэ үү?

Тэргэл саран тэнгэртээ хуучирч
буйг харна уу?

Уужим их далайд хүслийн нулимс
дуслахыг үзнэ үү?

Унаж буй навчис зүрх сэтгэлийг
чинь хөндөнө үү?

Тэсгим хүйтэн салхи уйтайяа үлээнэ.
Тэр л газрын бороо санаанаас үл гарна.
Өдрийн гэгээ бүдгэрч, үдшийн бүрүй ирнэ.
Өөр нэгэн шөнө ирж, эрин зуунаар үргэлжилнэ...

Аяа, амраг минь!
Зүүд нойрондоо л уулзаж явья даа,
Алхмын зайнд биднийг алсын уулс хөндөлсөж дээ.
Зүсэр нулимсаа тэвчиж, аньсага юугаа анья даа.
Тооломгүй олон үгс өвлийн бороо мэт цутгаж,
Тоймгүй нэлийх тэнгис далайд нийлнэ.
Диваажин хийгээд Дэлхий хайр энэрлээ дэлгэнэ.
Дэргэд чинь харин сарнай дэлгэрнэ үү,
зүрх зүсэх илд нумарна уу?

Хязгаарлашгүй орон зай,
Хэмжээлшгүй цаг хугацаа,
Төрөл дамжсан дотно харилцаа
Төсөөрч эгүүрд одож дээ.

Уй гашуу минь юунд надаас үл сална вэ?
Уйт мэдрэмж минь яагаад надаас үл хагацна вэ?
Гишгэсэн газар бүхэн чинь ул мөр нь илэрхий,
Гэрэлт олон од нэрийг чинь дуурьсгаад тодорхой.
Гэтэл өдгөө алин ч учир битүүлэг нь юуных вэ!

Цавцайх үүлс, ноёлог уулс руу
Хайраа би
Сэвшээ салхиар илгээнэ...
Сэтгэл зүрхээ сэвтээхгүй гэсэндээ
Сар болоод оддын гялбаанаас
нэхэл асууж,
Санаандаа би дурсамжаа энхрийлэн хадгална.

Аяа, хайрт минь, ард үлдсэн
амьдралынхаа
Ариухан дурсамжийг мартлаа гэж үү?
“Яасан ч нэгнээ мартахгүй” хэмээх
Яруухан шивнээг салхиар илгээгээч!...



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
2009 оны 8-р сарын 29,
Франц, Кап Мартин

Шөнийн Зүүд

(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн залуу насандаа бичсэн шүлэг)

*Эх бичвэр нь Ау Лак хэл дээр: "Moi Dêt"
Энэхүү шүлгэнд Оскарын 2 удаагийн шагналт хөгжмийн зохиолч Аль Каша ая хийж, Тони болон Эмми-гийн шагналт дуучин Лиз Калавей Суприм Мастер Телевизийн 4 жилийн ойн "Амар амгаланг бэлэглэхүй" концертоон дээр дуулжээ.*

Урьд шөнө би зүүдэллээ.
Унтах ор, дэрлэх дэрнээс
Анхил зандан агаарт үнэртэв.
Үргэлж бид хамт,
Үнэн хайр минь мөнх.
Амраг сэтгэлийн мөрөөсөл хөврөв.

Урьд шөнө би зүүдэллээ.
Улаан тоос бужигнасан энэ л
амьдралыг орхин
Арилсан оронд би хөл тавив.
Уул толгодын анхилуун үнэр,
Уй гуниг, зовлон шаналан
Амарлингуй сэтгэлээс хөсөр одов.

Урьд шөнө би гэртээ харилаа.
Ууланд бороо зүсрэн шаагихуй
Унаа тэрэгний жолоо эргүүлж,
Аглаг харгуйн адагт хүрэв.
Үнэн мөрөөдлийг урин дуудаж,
Үүлс тэртээд гунигтай хөврөв.
Хоосон чамин мөрөөдөл,
Хуурмаг ертөнцийн амьдралыг
огооров!

Энхэрхэн хайр минь!
Эрхэмсэг холын далайг тэмцэн
Эргэх голын усан зогсоо нь
үгүй урсана.
Учир нь тэнд хоног өдрүүд
тансаг,
Улбаалан ирэх амьдралын
өнгө тунсаг.
Учирлан хэлэх гомдол үгүй
найрсаг.

Урьд шөнө би зүүдэллээ.
Усгал цагаан хун болон
Уулсын дээгүүр би дүүлэв.
Эрх чөлөөг элин халин мэдэрч,
Өндрийн цасаар умдаалж,
Өнгийн солонгонд умбав.

Цагийн Сүүдэр

Эх бичвэр нь Ау Лак хэл дээр:
"Khuât Nêo Thời Gian"

Чи нүүдлийн шувуу мэт
Тэртээ алсад элин халина.
Би шөнийн шүүдэр мэт,
Буцаад агаарт замхран арилна.

Чи амьдралыг гийгүүлэх
Сарны гэрэл аюу.
Би алсад уусан далдрах
Үүрийн гялаан буюу.

Хүрээд ирсэн хаа холын хайр
Хөвөн үүлс мэт алсад санагдах нь
юуны вэ?

Хайрын үгс нь хайлган цайлган,
Халуун гар нь дулаан зөөлөн,
Хангал зүүдэндээ л учирч
явья даа.

Аяа, цаг хугацаа гэж!
Аниргүй шөнийн сүүдэр мэт
сэтгэл ямархан эмзэг?
Зөнгөөр учирсан хайр, зүрхнээс
цацарсан аялгуу сэрээж,
Зүүд нойрондоо л учран ханьсая даа.

Бахдал төгөлдөр гийгүүлсэн
Бадамлах наран чи аюу.
Зөөлөн анхилан үнэртсэн
Зэрлэг цахирмаа би буюу.

Эргээс алсрах завь мэт
Энгүй алсыг чи зорин одном.
Өнө мөнхөд чимээрхэн буух
Өвлийн бороонд би уяран үлднэм.

Хаа эртийн хайр

(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 20 орчим
настайдаа бичсэн шүлэг)

Эх бичвэр Ау Лак хэл дээр

Хорвоогоос хүн буцахад хонгор сэтгэл нь бүдгэрч,
Хайрын ам өчиг нь хөсөр мартагддаг юм сан уу.
Хаа эртийн нийслэлд хайлган амраг нь эргэлзэж,
Харийн өндөр шилтгээнд хайртай бүсгүй нь эрэгцэнэ!

Дуулим хөх огторгуй нулимс мэт сүүмэлзэхүй
Дур булаам инээмсэглэл бороон чимээнд анирлана.
Бүдэг харуй шөнө нойр хулжин шаналахуй
Бөхөж буй лаа мэт зүрх энэлэн лугшина.

Эрхэмсгээр алхан, мөнгөн үзэг барьж,
ихэмсэг дээдэстэй учран
Эрт нэгэн цагт эзэн мэт хэвнэг нөмрөн явлаа л.
Эгнэгт хоосон мөрөөдөл ор мөргүй арилан
Эрвээхэй мөрөөсөлд автан сиймгэр далавчаа дэвлээ л.

Хэргэм хүртэн, гүрэн улсыг хаанчилсан
богинохон зүүднээ
Хэрэм цайз нь балгас болон, уйд автсан хүмүүс үймнэ.
Ээ халаг, энхэр хайр хүчит салхин, хөвөх үүлнээ
дайгдан алдрав.
Эмзэг туяхан цэцэгс тэртээх намрын ууланд
гандан хагдрав.

Эрт нэгэн цагт намайг чи хайрласан сан.
Эрмэг залуу нас, энхэр гоо сайхнаа хоёр биендээ
зориулсан сан.
Эдүгээ гэтэл бүгд хоосорч, шөнийн харуйд
бүгээн лаа бөхнөм.
Эрвэлзэн сүүмэлзэх гэрэлд бид үйлийн
үрээр л холбогдном.

Эрхэм ариун судар дотоод
ертөнцөд цуурайлав.
Эрхийн бариад мөнх бусын
оршихуйгаас тонилму.
Өнө үргэлжилсэн зүүднээс алгуур
би сэрэв.
Өнөө тийн сэхээрч,




Сэтгэл зүрхний эзэн

Эх бичвэр нь Ау Лак хэл дээр: "Vuong Hoang"

Хожмын уулзалтаас хойш арван жил өнгөрч,
Өргөн гол, өндөр уулс бидний хооронд хөндөлсчээ.
Харанхуй энэ үдэш бид санаандгүй эгэн учрав,
Эрэг хавийн нутаг цэнгэл хөөртэй цэлэлзэв!

Улиран холдсон мэдрэмж шинээр ахин долгиж,
Урьд эртийн хайр давалгаа мэт өндөлзөв.
Аялагхан зүрх хөвсөлзөх нь баяр наадмын шинжтэй,
Алхаа гишгээ бүр нь аяс зөөлөн хэмнэлтэй.

Сэтгэл зүрхэнд гэрэл гийвч сэрэл бишүүрхэнгүй,
Сэм ажаархвал хөгжүүн мөрөөсөлд умбангуй.
Арван жилийн турш дурсамж байсан хайр
Анир чимээгүй, цээжнээ дүрэлзэн асах нь гайхмаар.








Ийнхүү бид олон төрлийн дараа ахин учрав.
Илүү үзэмж төгөлдөр, эрхэмсэг сайхан болжээ, та.
Долгилох зүрх бахдалтайгаар булиглаж,
Дотнохон нэгэн мөрөөдөл цээж дүүргээд ирэв.

Аяа, сэтгэл зүрхний Эзэн минь,
Бидний зам мөр цаг үргэлж сүлжилдэнэ.
Амьдралын минь босгыг та дахин давах нь энэ үү,
Билигтэй эртний аялгуу уянгалаг хэвээр дуурьсана уу?


Өнгөрсөн цагийн аялгуу дуурссан тэр л янзаараа юу?
Өнөө эсвэл зүрхний ая дан хөсөр мартагдаа юу?
Баглаа цэцгэнд шингэсэн хуучны ялдам үнэр
Бүсгүйн тансаг өрөөнөөс сэнхийн үнэртсэн хэвээр үү?

Дуун үл гарна, уруул үл хөдөлнө.
Дөлж бишүүрхэх нүднээ нулимс дүүрээд ирнэ.
Дурлалд хөхин баясч зүрх цохилох нь жигтэй.
Дөхөөд очьё гэхнээ эргэлзээнд хөл тушаатай.








Илээд авмаар ойр ч эрээд явмаар хол,
Нүүр тулан үзэвч далайн чанад мэт алс.
Илч халуун сэтгэлээр таныг би ажна.
Нимгэн манан мэт үг яриа замхарна!



Аяа, хангал халуун зүрх минь
Агшин зуур гунигаар зүсэгдэв.
Анхил сэтгэлийн зул бөхөж,
Амраг хайрын барилдлага тасрав!



Хурмастын Үйлчин хайрандаа умбаж,
Хонгор Үхэрчинтэйгээ үүрд цэнгэж,
Диваажингийн аялгууг ахин эгшиглүүлж,
Дахин нийлэх маань хэзээ сэн билээ!



Яруу найрагч
1980 оны эхээр
Грекийн Афин хотод,

Төрөл Ялгуусан Хайр

Элсэн давалгаа нэгэнтээ хуйлрахад
Эрдэнэсээр хэмжигдэх өдрүүд улирна.
Өнгөрсөн амьдрал дурсамж болж,
Өнийн явдлаас ангид оршино.
Биднийг хагацсанаас инагш,
“Баяртай” хэмээн салснаас хойш
Бүхэл бүтэн зуун түмэн өдөр...
Билгүүн орчлонд улиран өнгөрчээ?

Аяа, Хунтайж минь,
Амраг Хайр минь.
Би юу гэхсэн билээ?
Бусад нь юу хэлэхсэн билээ!



Орчлон ертөнц анирлавч...
Аяа, би яахсан!
Орь зүрхний гэрч
Анир чимээгүйхэн!
Алтан хаалга, алсын шилтгээн
Амраг хайрыг битүүмжилжээ!
Алдар нэр, эд баялаг
Алдуурсан сэтгэлийг далдалжээ.

Хайр минь эрх чөлөөг тэмцэнэ үү!
Улиран одсон өдрүүдийн дурлал
Хувь төөргийн дээгүүр элин хальж,
Урьдын адил дэлбээлэх болов уу?

Ахин бид учирснаас хойш
Алаг дэлхийд арван он улирчээ.
Хувь тавиланг юунд огоорном гэж
Халуун зүрх минь гунигтайяа лугшин
Хурмаст тэнгэрээс асууна!

Орчлон дэлхийн булан тохой бүхнийг гоён
Оройн дээд Бурхан шинэхэн цэцэгсээ дэлгэж,
Олон ч хавар айлчлаад буцаж дээ.
Орь сэтгэл эртийн хайраараа дутан ахуйд
Огоорч Бурхан минь тоодоггүй нь юуных вэ!

Хана хэрмээр биш ч гэлээ
Хоног хугацаа бүхнийг холдуулах юм.
Өнөөдөр болоод маргаашийн
Өнө мөнхийн хайрыг хүртэл
Өр зүрх ялгахын аргагүй.

Намар намрын хагдарсан навчис
Найртай сэтгэлийн дурсамжийг хучаа юу.
Хатуу өвлийн хахир салхин
Хайрын хос мөрийг үлээж,
Хайран жаварлан шуураа юу!
Бид хэн ч болон заяагдлаа гэсэн
Бүдэгхэн дурсамжаа мартаж санахын нигууртай.

Марталгүй санах нэг нь
Магадгүй тунчиг гуниглаж болох!
Мартаж орхисон нөгөө нь
Магад жаргалгүй ч явж мэдэх.

Эндүүрэлгүй бидэн хоёр
Энэ л дурсамжаа хамтдаа сэргээвэл
Эл бөгөөс диваажин байх буюу.

Жич: Халуун инээмсэглэл гэрэлтүүлэн
Өчүүхэн ч болов өөрчлөгдөөсэй хэмээн
Хунтайж танаа зориулав.
Өөрчлөгдөж ч мэдэх л юм даа!

Ханхүүд

Парис хэмээх зуушийн газрын дэргэд
Ингэтлээ олноор цугласны учир юу вэ?

Аяа, Ханхүү байх чинь!

Зүйргүй ихээр хөвсөлзсөнөө
Зүрх минь лугшихаа больчих чинь...

уулзах боломж бидэнд тохиосонгүй.

Бараг л мартаж дээ, би,

Та минь ийм сайхан сан билүү.

Бас тэгээд он цагийн улиралд

Та илүүтэй сэтгэл татам болсон нь энэ үү.

~ Билэг оюуны оч

Таны нүдэнд гэрэлтэнэ.

~ Билгүүн суу намба таны царайд гийнэ.

Чин халуун үгс тань олныг дагуулна.

~ Би алсаас хайр, биширлээр харж,

Танаараа бахдан бахархана.

Та улс үндэстний хувь заяаг нуруундаа үүрчээ.

Тансаг гоо сайхан тань зүрх бүхнийг уяраажээ.

(миний зүрх хүн хүнийхээс илүүтэй уясна л!)

Эрхэмсгээр зорилгоо тэмцэн явахыг тань харахуй

Элэг зүрх минь тэнүүн болоод амгалан.

Гэрэлт инээмсэглэлийн тань чанад гэтэл

Ганцаардлын манан бүүдийх нь юуных вэ?

Тандаа би бүхнээ өгөхсөн,

Та минь л харин сэтгэл тэнэгэр яваасай.

Хуурмаг манан шиг энэ хорвоогийн

Хувь дутсан зэгэл өдрүүдэд

Хажууд тань байж, гарыг тань атгах сан.

Газрын диваажингийн суу дүрийг,

Гайхамшигт Эдений сүр барааг

Гялбалзууланхан тандаа харуулах сан.

Сэтгэл зүрхийг тань дуулан хөгжөөж,

Сайхан таныгаа илбэн таалах сан.

Айлчлан хүрэхүйн хувь таныг тойрсон
Алсын алс газрын аялгуу дууг тоглох сон.
Аян замд минь учран тохиосон
Адбиш гайхалтай түүхийг хүүрнэх сэн.

Ядарч алжаасан тархи толгойг тань
Ягахан үүлсийн дээр дэрлүүлэх сэн.
Янаг ариун хайрын цэцэрлэгээр дагуулж,
Язгуур зөөлөн аялгуу дуурьсган,
Ялгуун дулаан лааны гэрэл дор
Ялдам сарнайн үнэрт усанд таныг булхуулах сан.

Ухаарал хийгээд гайхамшиг дүүрэн
Урьдын домгийг тандаа хүүрнэх сэн.
Аль эсвэл зуны борооноос сайхан,
Аагим Дорнын лянхуа цэцгээс гоёхон
Амтат мөрөөдөл рүү таныг илгээх сэн!

Эс бөгөөс унаган багын зангаараа
Кино театрт туулайчлан ороод,
Кока кола залгилан, эрдэнэ шиш идэж,
Элдэв үзэгдэлд инээд алдан, хөмсөг зангидаж,
Эрээ цээргүй дүрийг уурсан харж суух сан.

Удаад нь бид хятад ресторанд очно,
Уран савхны гайхамшгийг та үзүүлнэ.
Эсвэл бид суугаад зүгээр л гараа барилцана,
Эрхэмсэг цэцэрлэгт, үдшээр хөхин зугаалж ч мэднэ.
Халуун зуухнаас гаргасан хачиртай гамбирыг амтархан,
Хэнд ч хамаагүй яриаг өвөр зуураа дэлгэх биз.

Аяа! Таны минь сэтгэл татам төрх
Амраг хүслийг хэзээ хэзээнийхээс илүүтэй булааж,
Ариун мөрөөдлөөр жигүүрлэн хөвсөлзүүлнэ.

}

Хөгжил баяр, аз жаргалыг
Хуваалцах хэн ч үгүй бол
Хүний амьдралын утга юунд!
Ганцаардал гэгч үе үехэн
Гансрааж орхих нь өршөөлгүй хүнд!

...Тийм шүү! Хувь заяаны хөшиг хаагдахаас өмнөхийг
Холхи амьдрал шинэхэн хуудсаа нээхээс урьдахыг
Хоёул бид дурсан санасаар ахуйд,
Хоёр биенийхээ нүдийг ширтэн
Хослон цэнгэж найрсан явахуйд,
Ариун хайр маань Амьд байхад
Амраг бидэн тийм л байсаан.
Өнөө бидний хэн хэн нь

Энэ дэлхийд хангалуун бус ч
Эгэн та бууж ирсэн нь юутай сайхан.
Биет ертөнцөд
Биесээ хальт харж,
Бид сүүлчийн удаа уулзаж дээ!

Амьдралын хүрдэнд хүмүүн бидэн
Хичнээн ч удаа учран золгож,
Хэдэн ч удаа хагацаж салаав дээ?
Хэлж хайрла, хэдэн удаа вэ!
Хэдий ойр ч хэтийдсэн холын
Төрөл ялгуусан хайраа харахуй
Тэсэхүйеэ хэцүү ч тэнүүн жаргалтай!
Зүрх сэтгэл долгион долгилох чинь!
Зүйргүй эртийн газраа хүсэн тэмүүлээд яах,
Зөндөө илүүг мөрөөсөн хүслэн болоод ч яах...

Төгс гэгээрсэн Их Багш Чин Хай
2009 оны 8-р сарын 15
Франц, Кап Мартин



Ханхүүд баяр хүргэе

Ерөөл талбигчдын далайн чанадаас
Ер бусаар гэрэлтэх хайртынхаа царайг харахуйяа бэрх.
Ерөөлт үгсээр урам зориг минь бялхана.
Ирээдүйн энх тайван, хөгжлийн гялбааг
Ирэх хаан эхлүүлэх болуужин хэмээн
Зарим хүмүүс инээмсэглэн бодно,
Зовхиндоо нулимстай нөгөө нь бэлэгдэнэ.
Шидэт энэ л газрын найрсаг хүмүүстэй хамт
Сэтгэл зүрх минь хөхин баясна.
Дээдэс таны эрхэм албанд
Дээд тэнгэр, газар дэлхийн алив сайныг
Дээш дээш нь дэвшүүлэн хүсье.
Адислал ивээл дүүрэн,
Алхах зам тань дардан,
Айлсах өдрүүд тань дурдан,
Аав л ижий тань Бурханы орноос
Алт шиг хүүгээрээ бахархан байг ээ.

Тэнгисийн эргийн зочид буудлаас
Талархал дэвшүүлж, хүндэтгэл илгээн
Чимээгүйхэн, нэгэн бүсгүй дээдэс танаа
Чин сэтгэлийн ерөөл талбиж сууна!

Улс гүрнээ засаглаад та минь завгүй,
Уулзах замын бэлчир биднээ дөтгүй.
Хэдий тийм ч зүрх сэтгэлд минь
Хувирч юу ч өөрчлөгдөөгүйг
Харин та минь мэдээсэй!
Эгэл гариг дээр та онцгой нэгэн Ханхүү!
Энэ л түүхийн хүрднээ учрал тохиосон
Эрхэм дээдэс танаа
Аз жаргал, баяр баясгалан,
Амьдралын алив сайныг хүсэн ерөөмү...
Ашид Бурханы Орон амарлингуй байг. ♥

Лондон

Их том хот юм аа, Лондон гэж,
Итгэж хайрласан онцгой түүнтэйгээ
Ижилсэн явах боломжгүй бол
Итгэл алдарч ганцаардахад төвөггүй ээ.


Ялдам түүнийгээ мартъя гэж бодлоо,
Яахин гэвч мартах билээ?
Яг л уул өөд мацах мэт хэцүү!
Хайр сэтгэлийн мянга мянган жилүүд
Халуун зүрхэнд минь сийлээстэй!
Хойт төрөл гэж байдаггүй юм бол
Хонгор сэтгэл түүн рүү тэмүүлэх нь юуных вэ?

Хэнд би зовлонгоо тоочихсон билээ?
Хорвоо дэлхий чимээгүй л дүнсийх юм даа.

Эрхэм сэтгэлийн эзэн чанар минь хэлээч,
Эдүгээ юмс ингэтлээ хувирсан нь юуных вэ?
Бидэн хоёрын дунд
Боломж эрэгцэх нь магадтай юу?
Бодол санаа үймрэн дэнслэх нь яасных вэ?

Саран гийж,
Одод гялалзана.
Сэвшээ салхин энхрийлэн илбэнэ,
Котье д'Азур өнөд цэнхэртэнэ.

Нэг л өдөр учран тохиох
Диваажин хэзээд төгс.
Надад тохиосон нь гэтэл
Дутаж гачигдах нь юуных вэ?



Ялдам зөөлөн дуу хоолой,
Янаг энхрий уруул нь
Сэтгэл татаж, хүсэл бадраана.
Сувд мэт очтох нүд,
Эрхэмсэг дүр төрх нь
Энгүй жаргалд умбуулж,
Өндөр тэнгэрийн энгээр
Өр зүрхий минь оволзуулна!

Аяа, би яахсан билээ?
Амраг ханхүүдээ хэрхэн хүрэхсэн билээ?
Тэр минь намайг санахаасаа өнгөрч,
Тэнгэрлиг хайр минь мартагдаж дээ.
Чамайг гэх миний сэтгэл
Чанадын диваажинг ч бялхуулам байхад
Чи минь санадаггүй нь юутай харуусам!

Гэлээ ч цугтаа бид энэ л амьдралдаа,
Гэмгүй энэхэн дэлхийдээ
Гэрэлт өөрчлөлтүүдийг хийнэ гэдэгт би итгэнэм.

Харин үүнийг эгэл даруугаар
Хайлган эмэгтэйн журмыг сахиж
Хайртай түүндээ хэрхэн хэлнэм?

Бүхий л орчлонг баясган цэнгүүлж,
Бидний зүрх цугтаа цохилох,
Хорвоод ирэх тэр л өдрийг
Хүлцэнхэн хүлээе дээ, би чинь.

Бурхан Эцэгтээ залбирму,
Биелэл орших болтугай!

Амраг хайр минь

Түнэр шөнийн уртад,
Тэнгис далайн аглагт
Хөлөг онгоцны гэрэл холхи тэртээд гялалзана.
Харин сэтгэл зүрхэнд минь
Халуун нэгэн мөрөөдөл гэрэлтэнэ.
Орь зүрхэнд юугаар ч сольшгүй
Онцгой нэгэн хүслэн буй.

Орд харш огоот үгүй
Онгон тэнгист амьдрахыг л хүсмүй.
Хамаг оршихуйд минь гүн шингэсэн ч
Халуун зүрхнээс алс хол
Хэн нэгэн хүмүүнийг
Хэтийдэн санаж энэлэхээс
Халгаж байгаа нь тэр!

Энгүй тэнгэрээс бороо шиврэх нь энэ үү,
Эсвэл нулимс аяндаа асгарах нь тэр үү?

Удаж чадахгүй нь ээ би, Лондонд.
Учир нь гэвэл үгүүлэн санахын уй зовооно.
Аяа, өнө эртний цайз минь,
Амраг түүнээ дурсан бодсоор
Алслан холдож чадахгүй бол яана...

Аяа, аль эртийн хайр минь,
Амраг бидэн энэхэн чөлөөнд
Амьсгалах агаар нэгтэй биш үү.
Ая тохиолоор учрах завшаан
Ахин нэгтээ тохиохсон ч билүү!

Идэхийн тулд л хүмүүс амьдарч харагдах юм,
Итгэл сэтгэлээр л харин би оршном!

Харуусал гунигийг ардаа орхин
Хаа нэгтээ улиран өнгөрч,
Хоног өдрүүд чанагш одном!

Халуун гарыг нь хэрвээ атгаж,
Хоромхон зуур ч гэлээ
Хосгүй цэнхэр нүдийг нь ширтвэл
Харуусал гунигаа мартан
Халин одоход ч би бэлээн.
Хайр сэтгэл өөр юугаар дутахсан билээ.

Өртөөлөн ирэх амьдралдаа
Өгөөмөр хайр дурлалтайгаа
Өнөд жаргалтай амьдрахыг л хүснэм.

Үнэр ялдам харгуй

Зочид буудлаас гарч,
Зуушийн газрыг зорин,
“Үнэр ялдам харгуй” хэмээн
Үлгэрлэж миний нэрийдсэн
Үзэмжит цэцэрлэгээр алхахуй
Үүрд дэлбээлэх цэцэгс
Үнэртэн сэнгэнэм билээ.

Энэ дэлхийн хамгийн тансаг хотод,
Эгэлгүй ханхүү болон заларч,
Эрхэм таны оршин байгаад
Энгүй баяртай байнаа, би!
Орон улс нь яг л эзэн шигээ
Оргилуун болоод дэврүүн.
Үлгэрийн шидэт хаант улс
Үнэхээр байдагт итгэнээ, та.
Эндхийн агаараас та
Элгэн хайрыг мэдэрнэ.
Энд тэндхийн хүмүүс
Энэ л хайранд татагдана...

Харин нэг л зүйлээс би аюуна,
Ханхүүгийн харшид очихоосоо
Халгаж байснаа нуух юун.

Анх удаа очсоныг ч хэлэх үү,
Ай түмэн нууц дуран
Алхам бүрийг минь мөшгихийг яана.
Албархуу гэхэд ч багадмаар
Ай даа, даржин айлчлал болсон доо.

Халаг гэж!
Харшид маань маргааш ирээрэй гэж
Ханхүү эелдгээр урихдаа
Хаалгаар нь орохоос өмнө
Хальчихаж мэдэх миний
Халширсан байдлыг яаж чиг мэдэх билээ!
Харин би “баярлалаа” гээд
Хариуд нь ТАТГАЛЗАЖ орхилоо!!!

Оюун ухаан огшоож,
Он жил улирнам.
Урьдын алдаандаа харуусч,
Тэр минь намайг ахин
Уриасай хэмээн хүснэм.
Тэгвэл үхэхэд гомдох юун.

Тийм ээ! Би таныхаа төлөө,
Тэнгэрлиг хайраа гэсээр үхэж чадна.
Үнэндээ би дэндүү бүрэг байжээ!
Үүнээс үнэтэй зүйл гэж энэ дэлхийд юу байхав,
Үүнээс эрхэм амьдралын утга ч гэж яаж байхав...

Энэ бүхнийг би мэдээгүй явж,
Элгэн хайранд дасаагүй байж.
Эргэн учрах боломжийг бидэнд ахин өгөөч,
Эрхэм нандин заяаг бидэнд дахин хайрлаач.
Эрсэн эрдэнээ атгачихаад
Эргүүлээд алдахын бэрхийг би мэднэ.

Урьд насны амьдрал,
Угтах маргааш ч гэж үгүй мэт.
Хэн хэнээ танихгүй,
Хэзээ ч бид учраагүй мэт!

Үзтэл нэгэн удаагийн хайр
Үүрд мөнх орчих буюу.
Олон төрөлдөө хамт амьдарсан болохоор
Арга ч үгүй биз...

Аяа, амрагхан хайр минь!
Айлсах нэгэн цаг дор эргэн нийлж,
Амьдрал юугаан жаргалтайгаар цогцлоож,
Илүү сайхан дэлхийг хамтдаа бүтээж,
Ирэх үеийг цугтаа үдэхсэн дээ.
Чинхүү энэ хүслээ хорьж дийлэхгүй нь,
Чин сэтгэл минь энийг л тэмцнэм!

Хэлээч, наран болсон
Ханхүү минь.
Халуун мөрөөдлөөс давсан
Хүслэн юм гэж үү дээ, энэ?

Ханхүү болон Хаант улс

Хаант улсад нь татагдаагүй юм шүү,
Хайртай хүндээ л тэмүүлсэн юм.
Ханхүүгийн нутаг жавхлан төгөлдөр ч
Харин та минь үгүй бол сэтгэл хорогдох юун!

Гэгэлзэх сэтгэлийг цэлмээсэн
Гэгээн дүр төрх тань
Онож хэлэх шалтгаан,
Онцлох тайлбаргүйгээр
Оюун бодлыг минь үймрүүлэх юм аа!

Магадгүй таны инээмсэглэл,
Машид уянгалаг дуу хоолой,
Эсвэл таны цэнхэрхэн нүд, зөөлөн харц...
Элэг зүрх минь чухам юунд татагдсаныг таашгүй!

Ханхүү минь, та ариухнаас ариун,
Хан хорвоо дээр
Хамгаас сайхан нь гэдгийг л би мэднэ!
Та минь хаа сайгүй харагдах юм,
Таныг би мартаж ер чадахгүй нь.
Таны зургийг харж,
Тань руу цонхон цаанаас
Талархан мэндчилж, үнсэлтээ илгээнэм.

Хайрт минь, сайн байна уу?
Хажууханд чинь,
Тун ойрхон байгааг минь та мэднэ үү?
Таныхаа дэргэд шахуу л байна,
Тантайгаа хамт байх л гэж тэр шүү.

Далдаас нэгэн шидтэн
Дохиур юугаа хөдөлгөн
Бидний замыг салгахад
Би ганцаар хаа нэгтэй үлдэн,
Та минь харш руу илгээгджээ...

Харин нэн хүчит сэрэл мэдрэмжийг
Хэзээ ч ид шидтэн үгүй хийж дөнгөхгүй!
Тэр хар шид нэг л өдөр арилахаас хойш
Тэвчин хүлцэхээс өөр яалтай.
Хайрын хүч ялан сацарна,
Хамгийн сайхан зүс царай,
Хайр булаам гэрлэн бүрхүүл
Холын холоос айсуу билээ...

Ямар ч шидэт үлгэр
Ямагт сайнаар төгснөм.

Харууслыг Жувалцахуй

Эрхэмсэг мутраа өргөхийн төдийд
Элдэв бүхнийг бүрэлдүүлэх хүчин төгс
Энэ орчлонгийн хамгийн хүчирхэг төрөлтөн,
Дээдийн дээд Бодьсадва,
Дэлхийн хааныг та төсөөлөөд үз дээ...
Энэ дэлхий дээрх
Хөөрхий хүмүүсийн адил
Хагацал үзэн өнчирч,
Эцэг эхээ тэр саяхан алджээ!

Уй гашуу, ганцаардлыг нь
Угтан ойлгох хүмүүн нэгээхэн бээр ч үгүй!
“Хамаг бүхэн”-ээ алдсан
Хөөрхий нэгэн охины
Эзгүйрч хоцорсон сэтгэлийг
Эрдэнэсээр үнэлэгдэх бэлэг сэлт ч
Эдгээн тайтгаруулж яахин чадах...

Эзэн хаантан минь ээ!
Эрхгүй биднийг харуусан гашуудахуйд
Эмзэг зөөлөн сэтгэлд маань
Эрээлэн мяраалах шаналалд
Бурхан хүртэл хүчин мөхөстөж,
Бодолд автан анирлана!

Харуусал гашуудал учраа гээж,
Халуун тэврэлт ч утгаа алдана!

∅

Зун цагийн амралтын үдшээр
Зоогийн газрын “нөгөө талаас”
Халгин цалгих хүмүүсийг ажинхан
“Хэн ч биш” нэгэн суунам!

Ханхүүгийн эзгүйд тэд
Хөөрөн цэнгэлдэж яахин чадна вэ?!!!



*Яруу найрагчийн
авсан гэрэл зураг*



❧ ДӨТГӨӨР ХЭСЭГ ❧

Тухайлан Зориулбай



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
2009 оны 8-сарын 8
Франц, Гэгээн Мартин Төв,

Төгс Гэгээрсэн Их Багш Чин
Хайн зурсан зураг: “Сүр жавхланг
хүндэтгэн үдэхүй”
2008 оны 8-сар, Франц, Ментон





Алтан Лянхуа

(Гүн хүндэтгэлт Thich Mãn Giác-ийн дурсгалд зориулав.)

Эх бичвэр Ау Лак хэл дээр: “Đóa Sen Vàng”

Алтан лянхуа хагдран унаж, дэлхийд үзэгдэхээ болив,
Аяа, гуниг дүүрэн гурван ертөнцийн хүмүүс
Алаг хорвоогоос таашаал хүртэх нь багасав.

Алтанхан лянхуа минь ээ,
Асар эрт биднээсээ та юунд алсран одов?

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

2006 оны 12-р сарын 15

ТЭРГҮҮН ЛАМ ТНІСН МАН ГІАС (1929-2006) бол Зэн урсгалын их багш, яруу найрагч, Ау Лакын (Вьетнам) түмэнд алдаршсан багш, сурган хүмүүжүүлэгч билээ. Дхарма сургаалийг дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан тэрээр ард түмэндээ “Ганцаардмал аялал” яруу найргийн цоморлиг, “Huyền Không - ийн найргууд”, “Зоргоор цагаан үүлс” зэрэг яруу найраг, дууны маш үнэ цэнэтэй бүтээлүүдийг үлдээсэн билээ.



Саёнара

(Гүн хүндэтгэлт Thich Mãn Giác-ийн дурсгалд зориулав.)

Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Sayonara"

Буян төгс Гэгээнтэн Диваажин өөд морилов.
Будант ой намрын салхинд гашуудан ганхав.
“Хөнгөнөөс хөнгөн өдөн адил”, та мину
Хэлбэр төдий хуурмаг энэ ертөнцийг орхив.

Ямархан өгөөмөр сэтгэл, дурсамж дүүрэн амь
Яахин амарлингуй, чанадын ертөнцөд одов?
Ариун номын дуулал тань агаар мандалд үнэр ялдам сацравч
Алтан шаргал өмсгөл тань салхинд намихаа больж дээ!

Өөд морилсноос тань хойш цэцэгс өнгөө сольж,
Эрт цагийн сүм хийд танд мэхийн ёслох мэт ээ.
Өөрийгөө огоорч тунхаглан,
Удамбар* цэцэг адил эрдэнэсийн ертөнцөд
Уугуул Чанартаа нэгдэхээр та минь явж дээ.

2006 оны 12-р сарын 16

* Удамбар: Хиндугийн домгоор бол мянган жил тутамд нэг удаа
цэцэглэдэг домогт цэцэг юм.



Тэнэт л Hoàng Cầm-г зориулав

Эх бичвэр Ау Ллак хэл дээр: "Хиѣт Бѣт Cho Hoàng Cầm"

Амьдралын наран жаргах **алтан*** бүрүйгээр нэгэн бээр
Гэртээ морилов.

Үзэх зүүднээ тохиох сэхээрэл **мэт***,
Аянч тогоруу, болорын цацраг адил шүлгийн уянга мэт
Үүл хөлөглөн буцах үнэний зам нь үнэр ялдам буюу.

Wu Tzu - 2010 оны 5-р сарын 7

* Хөгжмийн алдарт зохиолч Hoàng Cầm-ын бүтээлээс ишилжээ.

HOÀNG CẦM (1922-2010) - Kinh Bắc нутгийн яруу найрагч бөгөөд жинхэнэ нэр нь Bùi Tấn Việt Тэрээр “Хайрлахын төлөө амьдарч, бичиж туурвихад дурлаж” 88 жил амьдрах хугацаандаа Ау Лакын (Вьетнам) яруу найраг, хөгжмийн ертөнцөд оюун санааны аугаа их өвийг үлдээсэн билээ. Түүний нэрийг дуурсгадаг гарамгай бүтээлүүдээс дурдвал “Уран навчис”, “Điông мөрний нөгөө эрэг”, “Хойд зүгийн нийслэл”, “Шинэ оныг угтсан бодлууд” зэрэг яруу найргийн бүтээлүүд... түүнчлэн “Kiêu Loan”, “Nam Quan - ы эгдүүцэл” зэрэг шүлэглэлт жүжгүүд болно.

Thu Нò-г зориулав

Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Vê Thu Нò"

Аль эртийн сэтгэл нэн амгалан атал
Алтан **намар***-ын шаргал навчис хийснэ...
Хун шувуу салхины аясаар энэлэн уйлж,
Хязгааргүй орон зайд жигүүр юугаа хумина.
“Хагацлын гуниг”***-ийг тэр дууланхан*
Харуусалд автан **нуурын*** эрэг дээр бууна.

Хоргой торго мэт зүрх сэтгэл чинь тансагхан,
Хамба хилэн мэт билиг оюун тань тунсагхан.
Эрдэнэс гялалзах мэт горхи аялгуулан гялбалзана,
Хурмастын бороо мэт хөгжмийн эгшиг дуурсана!

Эдүгээ энэхэн ертөнц бүхэлдээ нэн амарлингуй,
Холхи **Нуур***-ын бараанд алтан **Намар*** бүдгэрэнгүй!
Хэдхэн хөг аялгуу цуурайлан үлдэж,
Хөхрөх тэнгэрийн хаяанд алгуурлан үдэлнэ!

Wu Tzu - 2000 оны 5-р сарын 19

* Хөгжмийн алдарт зохиолч Thu Нò-гийн бүтээлээс ишилжээ.

** Thu Нò-гийн дууны нэр

Thu Нò (1919-2000)-жинхэнэ нэр нь **Нò Thu** - билэг танхай яруу найрагч, жүжигчин, хөгжимчин бөгөөд орчин цагийн Ау Лакын (Вьетнам) хөгжмийн урлагт онцгой хувь нэмэр оруулсан авьяастан юм. Thu Нò хөгжмийн урлагт 50 гаруй жил зүтгэхдээ үлдээсэн уран бүтээлийн арвин их өв санд нь “Эх нутаг”, “Үдэш эгшиглэсэн лимбэний аялгуу”, “Биесээ санагалзахуй”, “Салж одохын харуусал”, “Үдшийн ягаахан ой” зэрэг 200 гаруй гайхамшигтай дуунууд нь багтдаг билээ.

Lê Uyên Phương - ᠑ зориулав

Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Gởi Lê Uyên Phương"

“Намаг балчиг”*-аас сугаран цойлох лянхуа цэцгийн адил,
Номин тэнгэрийн үүлсээс алсрах гэрэлт саран мэт
Өөр нэгэн амгалан **ертөнц**** рүү,
Өнө мөнхийн **ариун**** орон өөд та минь морилжээ.
Усгал зөөлөн сэтгэлийг тань урин дуудаж,
“**Уйтайхан өдөр****” таныгаа үгүүлэн гансарнам...

Үдшийн бороо, өглөөний шүүдэр мэт,
Үнэндээ энэ хүмүүний амьдрал хоосон зүүд билээ л.
Учир шалтгаан, хувь тавилангаар
Усан онгоц зангуугаа нэгэнт өргөжээ.
Өнийн гүн бишрэлдээ цор ганц сэлбүүртэй
Өнөөх хүмүүн өөр ертөнц өөд аялнам!

Wu Tzu - 1999

* Lê Uyên Phương-ийн дууны хэсгээс авчээ.

** Дуучин, ая зохиогч Lê Uyên Phương-ийн бүтээлээс ишилжээ.

LÊ UYÊN PHƯƠNG (1941-1999) - Ау Лакын (Вьетнам) авьяас төгөлдөр хөгжимчин. Түүний нэр ард түмэндээ танигдсан авьяаслаг дуучин Lê Uyên Phương хэмээх сэтгэл нийлсэн андынх нь нэртэй ямагт цуг дуурсагддаг юм. Тэрээр “Бидний аргагүйдэл”, “Чамд зориулах хайрын дуу”, “Уйтгар хэр удаан үргэлжлэх бол?” ... зэрэг мөнхийн хайрын дуунуудаа дэлхийд үлдээсэн юм.

Thái Hằng - ᠑ зорьувал

Эх бичвэр Ау Лак хэл дээр: : “Gởi Thái Hằng”

Бие биесийнхээ сэтгэлийг ойлгоё гэхнээ
Битүүхэн гуниг үл дурсагдах нь юув!
Түнэр уйтгарт булшийг чинь эргэн очиход
Тэнгэрлэг хоосон чанарт та минь дэвшиж дээ.
Цаг хугацааны хүрдэнд бидний хайр
өнө мөнх* болохоор
Цохилох зүрхний барилдлагыг **ноён**
оргил* ч зааглаж яахин чадах вэ...

Wu Tzu - 1999 оны 8-р сарын 14

* Ау Лакын алдарт дуучин Thái Hằng-ийн бүтээлээс ишилжээ.

Phạm Duy - ᠑ зорьувал

Эх бичвэр Ау Лак хэл дээр:

Ажин түжин улирах өдөр
хоногийг тоолсоор
Амьдралын хүрдэнд нэгэн бээр
гагцаар үлдмой.
“**Танц минь, ганц минь**”^{*} хэмээн
мөнхөд^{**} дурсах
Ганган сарнайн улирал эргэж үл
ирмой!

* Ау Лакын авьяаслаг хөгжмийн зохиолч Phạm Duy-гийн бүтээлээс ишилжээ.

** Ау Лакын алдарт дуучин Thái Hằng-ийн бүтээлээс ишилжээ.

THAI HANG (1927-1999) – Хэдэн мянган жилийн соёл иргэншлийн өлгий Hà Thành нутгийн үзэсгэлэнт энэ бүсгүйн эцэг эхээс нь заяасан нэр Phạm Thị Quang Thái. Тэрээр хөгжмийн өв соёлыг шингээсэн гэр бүлээс гаралтайн дээр хөгжимчин Phạm Duy-ийн хайрт гэргий нь билээ. Thái Hằng-ийн хоолой, алдар нэр нь Thăng Long Choir болон Phạm Duy нарын гайхамшигт дуунуудтай салшгүй холбоотой. Ау Лакын (Вьетнам) дуу хөгжмийн хорхойтнууд түүний уянгалаг хоолойг “*Тэнгэрийн лимбэ*”, “*Нутгаа санагалзахуй*”, “*Хайрын аяз*” зэрэг олон дуугаар нь дурсан санагалзсаар байдаг.

PHAM DUU (1921 онд төрсөн) - жинхэнэ нэр нь Phạm Duy Cẩn. Тэрээр хайр болоод ард түмний тухай, оюун санааны дэвшлийн талаар гээд өргөн сэдвээр хөгжмийн маш олон төрөл маягаар үлэмж олон дуу зохиосон ба зарим нь Ау Лакын ард түмний сэтгэлд мөнхөрсөн учраас түүнийг Ау Лакын (Вьетнам) орчин цагийн хөгжмийн “алтан мод” хэмээн хүндэтгэдэг. “*Хайрын аяз*”, “*Нутаг ээж*”, “*Жүржсийн зам*”, “*Вьетнам эх нутаг*” зэрэг дуунууд болон хожим хэвлэгдсэн “*Kiêu* -ийн тууж” зэргийг жишээлэн дурьдвал зохилтой. Түүний домог болсон дуунууд Thái Hằng, Thái Thanh, Lê Thu зэрэг олон дуучдын мөхөшгүй хоолойнд жигүүр ургуулж, Ау Лакын хөгжмийн тэнгэр улам өндөрт нисэх шидийг өгсөн билээ.

Эгэл Баатар

(Үйлс нь ариун цагдаа нарт зориулав.)

Тэсгим өвлийн жихүүн салхинд та
Тэртээх дорнын сүрлэг хөшөө мэт зогсном.
Даамай их зүрх зоригийн тань өмнө
Далайн шуурга ч давалгаа юугаа эвхнэм.
Зуны үдийн тоост бүгчим халуунд
Зүдрэл гомдол бүхэн эгэлхэн инээмсэглэлд тань сарнина.
Ээх өндрийн наран ч тэвчээр юуг тань сорино.
Эмх замбраагүй замын хөдөлгөөн дунд
Таны итгэлт гар бүхнийг зохицуулавч
Талархал хүлээх нь ховор доо, ховор.

Ай гэхийн чөлөөгүй замаар хурд хэтрүүлэн давхих үед
Аюул ослоос сэрэмжлэхийг хэлж өгдөг билээ, та.
Түнэр шөнөөр түгжээнд гацаж мунгинахын цагт
“Тавтай аял” хэмээн зохицуулж, инээмсэглэн үддэг дээ, та!
Түвэгтэйхэн замын голд төөрч будилахын үед
Товч замыг зааж, чиглүүлж үлддэг ээ, та.
Яг ч үгүй бас мэддэг хэлээр минь ярихыг
оролдсон гэж байгаа,
Яах вэ, их хичээсэн л дээ...

Хахир хэцүүтэй нь хатуу харьцаж,
Хайлган цайлганд нь зөөлөн ханддаг аа, та.
Хүмүүний олон ааш араншинтай
Хувиар учрах шаардлага ихтэй ч
Үнэндээ, итгэл төгс явдаг тань гайхалтай.
Үй олон арга барилаар
Үнэ цэнээ харуулдаг аа, та!

Анх уулзсан тэр л өдрөө
Андууралгүй санаж байнаа, би.
(Хөдөлгүүрт унадаг дугуйнаас
Хоёр дахиа осолд ороход)
Энгэртээ тэврэн замын хажуу руу намайг гаргаад
Эмч, сувилагчид хандан
“Ямар нэгэн юм хийгээч!
Яачихав аа? Зүгээр болох нь уу, тэр?” хэмээн
Яаран бачимдан хашгирч билээ, та.

Таны царай төрх
Сэтгэл нь зовсон эцгийнх шиг харагдсан сан.
Танаас сацрах гэрэл
Сахиулсан тэнгэрийнх шиг үзэгдсэн сэн.
Тэр л дүр төрхийг би
Санаа бодолдоо мартаж яахин чадах сан.

Тэгэхлээр би таныг сайн мэдэлгүй яах вэ.
Тэртээх харийн хотод ч,
Төрөлх бяцхан тосгонд минь ч,
Түнэр харанхуй, айдаст нарийн гудманд ч,
Тэнгэрийн наран бүүдийх далайн эрэг дээр ч
Та ганцаар голдуу, эс бөгөөс
Тэнгэр Бурхантай л хамт явдаг даа!

Өнөд удаан үргэлжлэх дайнд
Өдөр өнжилгүй оролцож яваа зоригт дайчин бус уу, та.
Хүчирхийлэл хийгээд шударга бусын эсрэг
Хөөрхий доройчуулыг хамгаалан,
Гэм зэмгүйчүүлийг өмгөөлдөг билээ, та.
Амар амгалангийн тул,
Аюул заналын эсрэг,
Эх орон нэгтнүүдээ, эсвэл зүгээр л над шиг
“Энгийн нэгэн жуулчин”-ы төлөө
Эгэл амьдралаа эрсдэлд учруулдаг аа, та...

Иймд миний адил олон хүн
Ийм л шүлгийг танд өргөх нь магад.
Эерэг сэтгэлээр нандигнан,
Элбэрэл хайраар баглаж,
Энэрэл хүндлэлээр битүүмжилсэн
Энэ л нэгэн даруухан бэлэг
Эгэл танаа урам болог.

Хэзээ нэгэн цагт
Харуй бүрүйтэй нүүр тулахдаа
Хүмүүс өөрийг чинь хайрладаг гэдгийг мэдээрэй,
Халуун сэтгэлийн энэхүү захиаг санаарай!
Таамаглахын эцэсгүй гажуудлыг нийгэм тэтгэсээр байна!
Тэгэвч бид бүгдээр түүнийг засаж эерүүлэх болно...

Онцгой цаг үе одоо нэгэнт иржээ.
Онцолж юуг хүсэхээ товлож амжаагүй л явна!
(Та минь ойлгоо байлгүй... цагдаад шүү дээ!)
Юутай ч хуучин жилийг халах шинэ оны босгон дээр
Зул сарын баярын мэндийг чин сэтгэлээсээ дэвшүүлье!
Юм юмаар баялаг өдөр хоногуудыг угтаж,
Зүйл зүйлийн жаргалант амьдралыг шинээр
цогцлоох болтугай!

“Муу муухай бүхэн” тэртээ хол хоцровч
Аюулгүйн баталгааг бэлгэдэх дүрэмт хувцсаа өмсөн,
Алдар сүрээ өргөж, бардамхан дуугарах цагдааг
Ард олны дунд алхалж явахы нь харах сайхаан.
Хүчтэй хэдий ч шударга, даруухан боловч аймшиггүй
“Хийдэг юмандаа хайртай” (*)
Та бол Эгэл Баатар.
Танд бид хайртай. ♥


♥ CDLA ♥

~~~ ♥ ~~~

(\*) *Монако-гийн гудамжинд таарсан нэгэн цагдаагийн хэлсэн үг.*




Яруу найрагчийн авсан  
гэрэл зураг



ТАВДУГААР ХЭСЭГ

Тэнгэрийн Хайр



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
2009 оны 11-р сарын 22  
Франц, Роквобрюн



## *Сэрж Сэхээрэгтүн!*

*Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Hầu Bìng Tình!"*

Унаган дэлхий минь, сэрж сэхээрэгтүн!  
Уул ус уйдан хямарч, ой мод энэлэн шатаж,  
Хавийн толгод элэгдэн үгүйрч, гол горхи ширгэжээ.  
Хөөрхий сүнснүүд эцэстээ хааш одохсон билээ?

Аяа, асар дэлхий мину, шөнөжин асгарах нулимсаар  
Шаналан юу тань амирлаасай.  
Аяа, тэнгис далай мину, аялгуу дуугаа бүү анирлаасай,  
Шантрал үгүй маргаашийн итгэлийг хүмүүст үлдээгээсэй...

Хамаг амьтан та мину, үг өчиггүй өнгөрөн одсон ч гэлээ  
Холын чанад ертөнцөд амарлин амсхий дээ.  
Халуун зүрхний минь цохилт намжаархан зөөлрөг.  
Харин би тэр зуур дэлхийн хүмүүсийн гэмшлийг хүлээж сууя.

Түнэр өтгөн ой минь, унаган төрхөө хадгалж,  
Түмэн олон хүмүүнийг төөрөлдөж явахад нь хамгаална уу.  
Үнэн зүрхнээс минь ундарсан нулимсны мянган дуслаар  
Үзэмж сүрлэг модод, үндэс мөчрөө усална уу.

Өр зүрх минь, өрөвдөн уйлахаа аядуул даа,  
Өнийн урт шөнүүдэд сүнсээ амарлиулая.  
Уйт зовлонд шаналагсдын төлөө мэгшсээр  
Урсах нулимс эгшиж, урсгах үг цөөрч дээ.

Аяа, түнэр шөнө минь, аян замыг нь гийгүүлэн,  
Аглаг харанхуйд бүдчих хүмүүн сүнснүүдэд гэрэл өгөгтүн.  
Аялгуу төгөлдөр хоосон чанарт нэвчин  
Амаржин тогтнож хайрла, амгалан байг сэтгэл минь.

Аяа, өдөр минь, амар амгаланг зүрх бүхэнд оршоохын тул,  
Ард олны тэмцэл зөрчлийг ашид намжаахын төлөө,  
Аяа гайхамшигт мөн чанараа бахдалтайяа гэрэлтүүлэхийн төлөө  
Аюул даллах гэнэтийн үймээнийг бүү өдөө.

Аяа, сэтгэл зүрх минь, тэсгим өвлийн жаварт  
Аюун тарчлагч шавьж мэт ахин бүү шаналаг.  
Тэнгэрийн суу дэлхийг чимэглэх  
Төгс маргаашийн тэр л өдрийг хүлээг.

Аяа, Бурхад хийгээд Тэнгэр Элч нар мину,  
Аврал эрэн би уйлнам, залбирнам, гуйнам.  
Үнэний Замаас төөрөн, тамын тойрогт хэрсэн  
Үйлт хөөрхий сүнснүүдийг энэрэн чөлөөлж хайрла!





Аяа, ах минь, сэргэ сэхээрэгтүн!  
Агуу их тэнгисийн дээгүүр бардамхан алхагтун.  
Асан дүрэлзэх наран өөд эгцлэн харж,  
Амьтан бүхнийг аврахын төлөөсөнд өөрийгөө  
зориулагтун!

Аяа, эгч минь, сэргэ сэхээрэгтүн!  
Алдарч сүйрсэн сууринаасаа өндийн босогтун!  
Эх дэлхийгээ бүгдээр нийлэн сэргээн мандуулья,  
Эвийн дуугаа цэнгэлтэйеэ дуулцгаая!



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
(Хиймэл үстэй нөмрөгтэй байгаа нь)  
2009 оны 11-р сарын 17  
Франц, Роквэбрюн



## *Битгий яваач!*

*Эх бичвэр Аю Лак хэл дээр: "Hāy Dìng Laj!"*

Өндөр настай ээж, гэнэн ахан дүүсээ бүү орхиоч!  
Өрсөн дайтах талбарт буу, сэлэм, улайрал буй ч  
Өс хонзон гэж хүмүүн бидний дунд үгүй юм шүү.  
Өөрийг тэнь элэгсгээр угтах дулаан гэр чинь байнам биш үү.

Хүмүүст зовлонгийн шалтгаан үүднэ, битгий яваач!  
Хорсол занал гэж байдаггүй юм аа, эрх мэдэлд л улайрсан хэрэг.  
Хаант энэ улс тоо томшгүй үхдлээр дүүрэх биш үү,  
Хайр энэрэл, энх амгалан, хөгжил цэцэглэл л энд цогцлох  
учиртай юм шүү.

Хайлган сэтгэлт аав, үр хүүхдээ битгий орхиоч!  
Хонзогнол дайсагнал гэж юу байхав дээ, заль мэх төдий л юм.  
Хүслээ хангахын тулд үндэстэнг бүхлээр нь устганам биш үү,  
Харин эндхийн амгалан тэнгэрт цаасан шувуу хөвөх  
учиртай юм шүү.

Өс санасан сүнснүүд орчиж, чөтгөр инээд алдсан  
Өөдгүй ийм замаар цааш битгий яваач.  
Харийн нутагт хөсөр унасан цэрэг эрийн сүнс  
Харанхуй ертөнцийн тоосонд төөрч явдаг юм!

Аяа, хонгор минь, алхаагаа алгуурлан бодолхийлээч.  
Амраг түүнийхээ ариухан гарыг атган,  
Гэр бүл, эх орон, дэлхий ертөнцөө бодон сэхээрээч.  
Гамшиг хийгээд үхэл зүрхэнд яагаад нүүрлэх ёстой гэж?

Тэсвэр тэвчээр зааж хайрла.  
Тангараг санаж, цус урсгах илд сэлэм бүү далай.  
Тулалдагч “мөнхийг дайсан”-аа ахиулаад сайн хар,  
Тэд чинь бас л таны л адил хүмүүс биш гэж үү?!

Миний дэргэд суугаад оюун санаагаа амарлиул.  
Мянга мянган төрөлдөө төөрч, хүйтэн уул, орь толгодоор  
хэрэн тэнэх сүнснүүдийг сонс.  
Улин исгэрэх салхи, бороонд тэдний зүрх уйтгарлан байна,  
Улирсан үеийн дайны үйлийн үрийн төлөөсөнд энэлэн байна.

Бид үхэж, бусад нь эрсдэн,  
Идэрхэн амьдралын гал цогтой ирээдүй гэнэт бөхнөм биш үү!  
Бас тэгээд гэр бүл, найз нөхөд, хайртай бүхэн чинь  
Ирт мэсний хорон сэтгэл, цусан балчигт өртнөм бус уу!

Хүйтэн салхи тулааны талбарт тоос дэгдээхүй  
Эрч хүч дүүрэн хүмүүний оршихуй,  
Энгүй их хүсэл эрмэлзлэл, идэрхэн мөрөөдөл,  
Халуун цус сад тавих нэгэн агшнаа үгүйрэн одно.

Хамтдаа шударга ариун амьдарч, цугтаа байцгаая л даа,  
Хөрш олон, ахан дүүс, аав ээж маань дэргэд байнам биш үү.  
Дэврүүн гол, мөрөөдлийн тэнгис, шүүслэг төмс, зөөлөн будаа,  
Дэнжийн цэцэгс, эрэг хөвөө бидэнд зориулагднам бус уу!

Эрт эдүгээгийн баатар эрс, баатарлаг эмс  
Энгүй олон төрөлтнийг цусаа урсгахаас аварсан юм.  
Энх тайван, хөгжил дэвшлийг тэд цогцлоож,  
Эвдрэл сүйрлийн оронд мөнхийн Үнэнийг тунхагласан юм.

Бусдын амийг хөнөөсөн бол өөрийнхөөрөө төлөх билээ л.  
Бусдын үхэл, хагацлаар цэнгэн баясч яахин болном?  
Биднийг цаглашгүй мөнхийн нинжин сэтгэл маань л  
Бүхийлэн төрөлтний дундаас онцгойруулан тунхагланам...

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
2009 оны 11-р сар  
Франц, Роквобрюн

# Будда-гийн Чулуун Хөшөөтэй Ярилцсан Минь

(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 30 эргэм насандаа бичсэн шүлэг)  
Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Nói Với Phật"

Энэлэнхэн битгий уйл даа, Будда минь,  
Энэ л ертөнцийн үйлийн хүрд гуниг зовлонгоор дүүрэн!  
Элэг зүрх гэгч энгүй балар ой,  
Эрхгүй бидний нулимс эгнэгт долгилох далай!

Гэрээдээ харьцгаая даа, Будда минь!  
Энэ л эрэг хөвөөн дээр үлдээд бид яахсан?  
Гэнэтийн хувирал дүүрэн эрээн мяраан ертөнцийн  
Энэлэн шаналанд зовнин санаашраад юу хийхсэн?

Нэгэн өдөр бороо орж, нэгэн өдөр наран мандана,  
Хамаг амьтан зовлонгийн балчигт хутгалдана!  
Нэг нь уйлж суухад, нөгөө нь дуулж явах юм аа,  
Хөөр баяр, гуниг зовлон цугтаа оршдог нь ч үнэн юм аа!

Энэлээд одоо яахав дээ, эрхэм Будда минь!  
Энэхэн дэлхийд баяр баясгалан тоотойхон.  
Наран мандавч удалгүй шингэх цаг нь ирдэг,  
Намуухнаар бүү гунихар даа, хайрт Будда минь!

Аяа, Будда минь, цугтаа явцгаая даа.  
Эгэл олон хүмүүн эргэн эргэн хоргодох,  
Асар зовлонт оршихуйг өнө мөнхөд тэмцэх  
Энгүй их төөрөгдлийн хий мананг орхиё доо...

*Чулуун Будда-тай  
хөөрөлдөхүй*

Амгалан байна уу, Будда минь? Юунд та уйлнам?  
Чулуун зүрхэнд тань хүслэн төрөө юү?  
Алагхан дэлхийн зовлонд энэлээ юү?  
Чухамдаа хамаг амьтаны зовиурт шаналаа юү?

Эрхэм Будда минь, яагаад та уйлнам?  
Эгээрэл хүсэл зүрхэнд тань үгүй гэдгийг би харнам!  
Энэрэл хайрыг тань шүрэнд нэвчээхээр  
Элбэрэлт Таны нулимс далай руу урсан байхыг би үзнэм!

Ая, Будда мину,  
Ариун гэгээн Нирвааныг  
Юунд Та орхив?  
Ая, Будда мину,  
Амьдралын сүүдэр харанхуйлсан  
Алаг эрээн дэлхийн  
Юуг нь та харнам бэ?  
Ая, Будда,  
Ая, Будда,  
Ая, Будда,  
Ая, Будда,  
Ариун гэгээн Нирвааныг орхих учиртайсан билүү?

Амгалан байна уу, Будда минь?  
Асгарууланхан Та уйлсаар л байгаа нь энэ үү?  
Эсвэл Таны чулуун зүрх  
Эргэх цагийн улиралд хайлан үгүйрсэн нь тэр үү?  
Энэрэл хайраар тань элсэрхэг ертөнцийг услах гэж  
Элбэрэлт Таны нулимс горхилон урсахыг би харнам!



## *Үгүй дээ, Хайр Минь*

*(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 30 эргэм насандаа бичсэн шүлэг)  
Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Không Đâu Em"*

Үгүй дээ, хайрт минь, бид хахь ондоо хүмүүс биш.  
Тийм шүү, хонгор минь, бидний сэтгэл нинжин  
зөөлөн байсан юм.

Үүлэн чөлөөгөөр нисэн одох шувуудын араас элин халин  
Тэнгэрлиг ариун сүнс гэрэл сацруулан оршсоор л байнам.

Үгүй дээ, хайрт минь, бид хөрстөд сөргөлдөх гэж ирээгүй.  
Тийм шүү, хонгор минь, бид сүр жавхлант харшаас ирсэн юм.  
Үнэндээ толгой эргэм ертөнцөд замаа алдан төөрөлднөм.  
Тиймээс Диваажин алсад санагдаж, эрээн мяраанд  
хутгалдан явнам.

Хий зэрэглээн дундаас ариун Диваажинг эрж хай,  
энхрий хайр минь.  
Хязгаар нь үгүй мэт гүний дайдыг анзаархан сонс, амраг минь.  
Хоосон чанарын төгс замналыг төсөөлөн бод, хонгор минь.  
Хувь язгуурт чанараа Бурханы хүчээр гийгүүлэх болно, та минь.

Ариун Диваажин дахь анхны гэртээ эгэн очицгоох уу?  
Тэнгэрийн гэрлээр замнан тэртээх гэр лүүгээ явцгаах уу?  
Асарлах Хурмастын аялгуу цуурайлах сүрлэг орноо  
тэмцвэл яана?

Тэнгэрлиг хаанчлал биднийг хүндэтгэн урин дуудаж байна.  
Тэнгэрийн найрал дуучид зохирол төгс дуулцгааж,  
Тэртээх огторгуйн орон баясал төгөлдөр найрсахуйд  
Тэнгэрлиг хаанчлалдаа бид эгэн залрахын ерөөлтэй буюу!

## *Бие биеээн хайрлацгаая!*

*(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 20 эргэм насандаа бичсэн шүлэг)  
Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Thieng Nhai Di"  
Энэ шүлгийн аялгууг Оскарын 2 удаагийн шагналт, хөгжмийн зохиолч Аль Кашиа туурвиж, Ли Аллерс, Тони болон Эмми-н шагналт Лиз Калавей, Грэмми-н шагналт Кашиф, Грэмми-н шагналт Мелисса Манчестер, Тони-н шагналт Мельба Мүүр, Тони-н шагналт Карен Зимба, нарын дуучид Суприм Мастер Телевизийн 4 жилийн ойд зориулсан "Амар амгаланг бэлэглэхүй" концертоон дээр дуулжээ.*

Чи бидэн нэгэн амьтай.

Халуун дотноор тэврэлдэж, баяр жаргалаа хуваалцъя.

Чиний сэтгэл гундвал би дэмжье,

Хатуу зөөлөн амьдралыг хамтдаа л туулья.

Хэрвээ ах минь, та хажуугаар өнгөрөн явбал

Хэзээ ч бидний харц ахин тулгарах нь үгүй.

Харин бид маргааш хорвоогоос халин одвол

Хагацлын агшнаа амьдралд хоргодох нь дамжиггүй.

Урьдын нөхдөө огоорон одох нь харамсалтай,

Уулзалт юугаа хачирлан ярихгүй нь харуусалтай.

Хонгор эгчийн гоёхон цэцэрлэгийн

Хашааны хаалга түгжээтэй буй нь хяслантай.

Хөлийн мөр нь тоосонд дарагдаж,

Халин одож мэднэ, та.

Таны үгүйд гундсан амьдралыг харахаар

Тосгон руугаа ганцаар явна, би!

Хайраа түгээцгээе, бие биендээ.

Хаврын улирал цэцэгсийг илгээнэм,

Хангайн модод ногоон бэлэгсийг баринам,

Хараад ханашгүй сайхан гариг мину!

Шөнийн тэнгэр гялбалзаж,

Цагаан гэгээ үүрийн хяруунаар туяарнам.

Шувуудын дуу найрсан цуурайлж,


Царцаа царгин, зун ирснийг тунхагланам.

Тэнгис далай, гол мөрөн урсаж,

Ой модод шаргал цэцгэнд ууснам.

Тэнгэрийн уудам зай хөхрөн нэлийж,

Онгон ариун нутаг алсран цэлийнэм.




Бие биесээн хайрлацгаая,  
Борооны улирал шинэхэн болоод сэрүүхэн,  
Бал бурам мэт голын ус нь амттай,  
Бид бүхний дунд хайр энэрэл дүүрэн.

Өгөөмөр хийгээд төгс төгөлдөр хайраар,  
Өрлөг Дэлхий, Тэнгэр Бурханы ивээлээр,  
Өнийн их хүмүүн заяаны энэрлээр  
Өдрөөс өдөрт амьдрал баяр баясалтай болно.

Бие биесийнхээ төлөө л амьдарцгаая,  
Билгүүн ирээдүйг цогцлоохын тулд л оршицгооё.  
Алаг Дэлхий дээр Диваажинг бүтээцгээе,  
Амар амгаланг нэг нэгэндээ бэлэглэцгээе!

Тэгвэл хүмүүсийн шаналан арилна,  
Тэгэж гэмээ нь хайр энэрэл дэлхийг гийгүүлнэ.  
Тэнгэр элч нар мянга мянган орноо цэнгэн бүжнэ,  
Тэнгэрлиг Бурхан хийгээд хүмүүн төрөлтнүүд  
хөхин баясна!

Миний дотор орших Бурхан  
Ийм л ертөнцийг хүснэм!...



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
(Хиймэл үстэй хувцас нөмөрчээ)  
2009 оны 10-р сарын 3  
Франц, Гэгээн Мартин төв





Яруу найрагчийн  
авсан гэрэл зураг



## *Цаглашгүй хайр*


*(Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 20 эргэм насандаа бичсэн шүлэг)*

*Эх бичвэр Ау Лак хэл дээр: “Người Yêu Lý Tường”*

Мандах нарыг би өглөө бүхэн угтаж,  
Жаргах нарыг би орой бүхэн үддэг.  
Манай хашаанд цэцэгсийн үнэр өдөржин анхилдаг,  
Жирвэлзэх одод огторгуйд шөнөжин анивчдаг аа!

Анд найз шиг хүмүүс эргэн тойрон налайн  
Амьдрал гялалзаж байвал юутай сайхан.  
Амин хэмнэл навчсанд ч байдаг юм аа,  
Ариун хүслэн аялагхан инээмсэглэлийг чимдэг ээ.






Харцандаа та хаврын урийг тээн ирэхүйеэ  
Хангал торгомсог үс тань зуны салхин сэвшээтэй.  
Харин таны хээнцэр алхаа намрыг дагуулан буцна,  
Хилэн зөөлөн гар тань өвлийн жаврыг үргээнэ.

Та амьдралд баяр хөөр нэмэх гэж ирж дээ,  
Таны ялдам инээмсэглэл саран мэт мөнхөд гийгүүлнэм.  
Туяхан хөлийн тань доор намуухан горхи сэрүү  
татуулан урсахуйяа  
Тунамал хар хөрс шидийн мэт амилнам.

Хайр минь, та яг л сэргэлэн өглөө мэт,  
Харуй бүрүйн гайхамшигт агшин адил аа.  
Унтах нойрыг уяраан тайтгаруулах намрын сэвшээ шиг,



Учралын өдрөөр дуурсах хөгжмийн аялгуу ижил ээ.  
Та мөнх амгалангийн төлөөнөө оршном.  
Таныг айлчлан ирэхүй уул усан талархлын дуугаа  
өргөнөм!  
Ялдамхан харц тань тунгалаг усан мэт илэрхий!  
Ягахан уруул тань амьдралыг өнгөлөн тодорхой.

Зуны бороо, хаврын наран, алтрах гэгээ,  
Ягаан үүл, цэнхэр тэнгэрийн хайр мину.  
Зүүдэн мэт ертөнцийг дэвшүүлэх гэж та морилжээ.  
Ялдам сэтгэлийн аялгуунд бүхийлэн нутаг дуурсчээ.

Зүрх сэтгэл минь эрхэмсэг оршихуйн тань өмнө сөхөрч,  
Зүйрлэшгүй хайрын ертөнцийг бахдалтайгаар зорином.

Цас мөсний тэсгим улирлыг дулаацуулж,  
Агаарыг анхилуун, уулыг тансаг, голыг цэнгэг болгох гэж  
та морилжээ.

Цаглашгүй хайр таныгаа тэврэн угтахсан гэхээс

## Хайртай Шүү Хэмээн Таныг Надад Хэлэхэд

*Энэ шүлгийн аялгууг Оскарын болон Эмми-гийн шагналт, хөгжмийн зохиолч Билл Конти туурвиж, дуучин Тони-гийн шагналт Карен Зимба Суприм Мастер Телевизийн 4 жилийн ойд зориулсан "Амар амгаланг бэлэглэхүй" концертон дээр дуулжээ.*

Хайртай шүү хэмээн таныг надад хэлэхэд  
Хамаг л уй гуниг минь хийсэн одном.  
Уулан дээгүүр элин халих хун шувуу мэт  
Үүлэн дээгүүр би цойлонхон хөөрөн -  
хөөрөн - хөөрнөм.

Та гараас минь чанга атгахад  
Түнэр шөнөөр ч зүрх минь аялгуулан дуулнам.  
Тэнгэрийн одод тодоос тод гялбалзаж,  
Тэргэл саран миний л сэтгэлд бүжнэм.



Ид шидийн энэ л мөчийг  
Өнө мөнхөд үргэлжлүүлэхсэн!  
Илбийн гэмээр ийм л гайхамшгийг  
Өнгөрөөлгүй авч үлдэхсэн!  
Хоног хугацаа намжаархсан,  
Хайр сэтгэл үүрд сацарсан  
Сэтгэлийн гал үргэлж бадамласан  
Сайхан газрыг тэмцэн очихсон!

Хорвоо даяар бүхэлдээ цогцлон  
Хэзээд залуу сэтгэлийн дууг  
эгшиглүүлбэл  
Хамгаас гайхамшигтай тэр л аялгуу нь  
Хүмүүн бидний хайр байхсан!

Харин намайг л бүү орхи,  
Хэзээ ч ганцааранг минь л бүү үлдээ!  
Хамтдаа бид биелэхийн ерөөлтэй  
Халуун мөрөөдлөө хуваалцах билээ.  
Хэзээ ч ганцааранг минь л бүү үлдээ,  
Хэзээ ч...



## *Аяа, Диваажингийн Шувуу Мину!*

Аяа, Диваажингийн Гайхамшигт Шувуу мину!  
Өндөрт халин хаашаа ниснэ вэ?  
Ашид салхин үл шуурах уудам нутаг руу юу...  
“Өнгийн солонгон чанагш” нэр нь үл мэдэгдэх орон луу юу?

Үл төөнөх наран өөд ниссээр  
Элс нь үгүй эрэг дээр чи газардана буй за.  
Үүрд орших Бурхадын идээнээс хүртэж,  
Элгэн халуун сэтгэлээ умдаалан,  
Цангаа юугаа чи тайлна буй за.

Аяа, Диваажингийн Шувуу мину!  
Элин халин Гэрээдээ нис дээ!  
Аниргүй ягаан үүлсийн дээгүүр  
Эрх дураараа дүүлэнхэн өнгөр дөө...

Хосгүй хөнгөн даль жигүүр,  
Хамгийн нинжин зүрх сэтгэл,  
Хөгжмийн зөөлөн аялгууг дагавал  
Хүрэх газраа чи хүрнээ!

Эзэн Бурхан аялгуулан хүүрнэх  
Эцэсгүй хугацааны орондоо хүрч,  
Эгнэгт амгалан нууранд умбанхан шумбана, чи.  
Энгүй үзэмжит талбайд нааданхан тоглоно, бас.

Аяа, Диваажингийн Шувуу мину!  
Аугаа Нэгэнийг чи хамгаас сайн мэднэ,  
Ачтай буянтайг нь ч ч бас бүхнээс илүүтэй ойлгоно.

Хүчирхэг жигүүрээ дэвэнхэн намайг аваад нисээч!  
Хосгүй тэр орон луу би ч гэсэн явмаар байна.  
Гэртээ би харихыг хүснэ...  
Гэхдээ бас очихыг яарна...  
Алсын алс ариун Гэр минь!  
Аяа, миний Диваажингийн Нутаг минь!



## *Наран таньдаа дуулму*


Хязгааргүй огторгуйн дундах  
Хурмастын үнэт эрдэнэс ээ, та!  
Хүчин төгөлдөр сүрийг тань  
Хичнээн их биширнэм бэ, би!

Өглөөний шүүдрийг эгшээх  
Өрлөг таны харц  
Өнгөт дэлхийг гэрэлтүүлж,  
Өнөд дулаанаар гийгүүлнэм!  
Билгүүн орчлонд таныг мандахад  
Бүгд жавхлан төгс болном.

Таныг мандан гийхүй  
Сэтгэл амгалан болном.  
Инээж, уйлахын алинд ч  
Итгэлт нөхөр минь болсон  
Ижилгүй тандаа талархнам!

Биет энэ ертөнцөд  
Бүхний манлай шүү дээ, та.  
Халуун дулаан, буян хишгээ  
Харамгүй хайрладаг даа, та!  
Тоо томшгүй олон төрөлтний  
Тайтгарал нь болдог оо, та.  
Хайр энэрэл, буян хишгий тань  
Хэн үгүйсгэж чадах билээ!

Хэрхэн яаж танд талархахаа  
Хэлж мэдэхгүй байнаа, би.  
Үлэмж ихийн тань өмнө  
Үг цөөдөөд байх юм аа.  
Сүр жавхлангийн тань өлмийд  
Сэтгэлийн үг хомсдох юм аа!  
Та надад хичнээн хэрэгтэйг  
Тэнгэр Бурхан л мэдэх байх даа!  
Таньгүйгээр дэлхий ертөнц ямар байхыг  
Төсөөлж бодохын арга алгаа!




Эртний хүмүүс ч  
Таныг биширнэм,  
Эдүгээгийн хүмүүс ч  
Таныг дээдэлнэм.

...Танд би баярлаж,  
Талархлын нулимс унагаж сууна.  
Энэ бол сэтгэл зүрхний минь  
Эгэл жирийн дуулал юм...  
Танд зориулан бүтэн өдрөөр  
Талархлын дуугаа дуулмаар байна!

Үүрд та минь надтай  
Үлдэж хайрла!

Байнга та минь надтай  
Байж соёрх!

Наран таньдаа би хайртай,  
Үүнийг та мэдэхийн учиртай!



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
2009 оны 12-р сарын 11  
Франц, Гэгээн Мартин төв



## *Аяа, Саран Мину*

Аяа, саран мину,  
Яг л над руу  
Ялдамхан мишээх мэт  
Та юутай сайхан!

Таны гэрэл бүхэнд хүртээлтэй ч  
Та бидний хайрыг  
Хэн ч үл мэднэ,  
Хэн ч үл үзнэ!

Ийм удаанаар ялдамхан  
Инээж хэн чадах вэ.  
Та л ингэж чадна,  
Та л ганцаар тийн мишээж  
чадна!

Яруу найрагч  
1980-аад оны эхээр  
Италийн Рапаллод

Намайг дуулахад  
Уулсын дээгүүр тэргэлтэн  
Уудам огторгуйд ганцаар  
гэрэлтэж,  
Сэтгэл зүрхийг минь тайтгартал  
Сонсонхон бүждэг ээ, та...  
Сансар эрхсийн дунд  
Саран та үзэмж төгөлдөр,  
Сэтгэл татам билээ л.

Оргилсон баяр хөөр,  
Орь гунигийг минь хуваалцдаг  
Огторгуйн үнэнч найз минь билээ  
л.  
Үнэнч болоод итгэлтэй  
Үүрдийн анд минь ч та.

Түнэр харанхуй ууланд  
Түүчээлэн замыг минь гийгүүлдэг,  
Зовж шаналсан үед  
Зүрхийг минь та тайтгаруулдаг аа.  
Хэн ч танаас сайхныг  
Хэзээ ч олж харахгүй ээ!

Огторгуйд шуурга дэгдэж,  
Од үзэгдэхгүй харанхуйлж,  
Он цаг хуучирсан ч  
Онгон саран таныг би хүлээдэг ээ.

Миний оршихуйд та  
Мөнхөд гэрэлтэн манддаг аа.  
Алсын саран үгүй бол  
Амьдрал яахсан билээ?!

Тэргүүлшгүй цагаас инагш  
Тэнгэрийн уудамд орчин,  
Тэргэл туяагаа сацруулсан  
Таны өчүүхэн хэлтэрхийг ч  
Ямар ч үнэт эрдэнэсээр  
Яагаад ч би солихгүй ээ.

Танд дэлхий ертөнц хайртай,  
Танд би ч бас хайртай.  
Олдошгүй сайхан найз минь,  
Оршин байгаад чинь баярлалаа!

Тандаа би хайртай,  
Тэргэлхэн саран мину!  
Тандаа би хайртай  
Тэртээх гариг мину!



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
1991 оны 9-р сарын 22, Формоса, Шиху,  
Сарны Их Наадмын үеэр,  
Гурав Хоногийн Даяан Бясалгал дээр





## *Алсын Одод Мину!*

Алсын гэрэлт одод мину!  
Аяа, та нар минь хичнээн үзэмжит,  
Алаг орчлонгийн чанадын чанадаас  
Асанхан үзэгдэх нь ямархан тансаг!

Одод та бүхнээ зочлон,  
Орь хүслээ толилуулах сан.  
Дууны сайхныг зориулан,  
Дуулим сэтгэлээ дэлгэх сэн.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
2008 оны 9-р сарын 5,  
Франц, Гэгээн Мартин төв

Анивчин гялбалзах нь гайхалтай,  
Алсаас сэтгэл татах нь гайхамшигтай.  
Ийм онцгой, ижилгүй үзэсгэлэнт...оддыг  
Ингэхэд Бурхан яаж бүтээв ээ?!

Холын холоос  
Хайрыг тань би мэдэрнэм.  
Уудам огторгуйгаас сацарсан хайр  
Уугуул гаригт маань хүрэлцэн ирнэм.

Сайн сайхан,  
Сүр жавхлан хийгээд  
Алив үймээн самууныг ч  
Андууралгүй харсаан, одод минь.

Өнө мөнхөд гэрэлтсээр,  
Өнө мөнхөд хайрлагдсаар,  
Өнө мөнхөд янзаараа,  
Өнө мөнхөд өгөөмөр өө,  
Одод минь!

Энэ л бидний хүмүүн төрөлтөн  
Эгэл болоод дорой ч  
Эрдэнэсийн дээдээс илүүгээр  
Энхрийлэн хайрладаг аа, одод та бүгдийг.

Та бүгдтэй айлсан,  
Та бүгдтэй учран,  
Та бүгдтэй алга дэлгэн уулзахыг  
Хэдийнээс хичээж явнаа, бид.

Аяа, Хурмаст тэнгэрийн эрдэнэс мину,  
Алсын алсаас гэрэлтэх одон гаригс мину.  
Та нар минь ч бидэнд хайртай..., тийм үү?

## *Би*

Би – мөрийн хөтөлбөргүй  
улс төрч,

Би – хаан ширээгүй  
эзэн хаан,

Би – зэр зэвсэггүй  
дайчин цэрэг,

Би – зэм буруугүй  
хэлмэгдэгч,

Би – өстөн дайсангүй  
өрсөлдөгч.

Нөхөд хийгээд дайснууд бүгд  
Миний л дотор байнам.



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
(Хиймэл үстэй хувцастай байгаа нь)  
2009 оны 11-р сарын 8,  
Франц, Роквеврюн

## *Төөрөг Заяагаа Магтан Дуулья!*

*Энэ онцгой шүлэгт Оскар болон Эммигийн шагналтан, хөгжмийн зохиолч Билл Конти ая бичиж, олон улсын сапрона дуучин Жиоржиа Фуманти Суприм Мастер Телевизийн 3 жилийн ойн “Ногоон гараг, энх амгалан амьдралд баясахуй” концерт дээр дуулсан юм.*

Төөрөг заяагаа магтан дуулья!

Их Багшийн Телевизэд ивээл хайрласан

Тэнгэр Хурмаст, Газар Дэлхийд талархая!

Ил далд олон төрөлтөнд гялайснаа илэрхийлье!

Тайван амьдрал, аз жаргалын төлөөх үйлс нь

Ирээдүй цаг дор мөнх адислагдаг ээ.

Энгүй олон төрөлтний

Энэ болоод хойтын амьдралд хөгжил үүтгэхийн төлөөнөө

Энэрэл хайр, алив бүхнээ зориулан яваа

Эрэлхэг хамт олондоо талархал илэрхийлье!

Энэ л сайхан үйлсийг дэмжиж,  
Аз жаргалаа хуваалцаж буй хэн бүхэнд  
Элэг зүрхнийхээ гүнээс талархая!  
Адислан ерөөх болтугай, Бурхан та нарыг!

Үй олон үзэгчиддээ

Чин сэтгэлээсээ баяр хүргэе!

Үнэнч байдагт тань баярлалаа,

Итгэж явдагт тань гялайлаа.

Диваажингийн сайн сайхныг

Дээдийн хайрынхаа хамт

Дэлхий дахинаа хүсэн ерөөе!

## *Бурхан Чамд Хичнээн Хайртай Билээ!*

*Энэхүү бүүвэйн дууг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай шавь нартаа болон хайртай амьтдадаа зориулан, хамаг төрөлтөнд Бурханыг үүрд санаж явахыг айлтган толилуулжээ.*

*CD M037-д буй “Аятай тавтай амраарай, алдрайхан мину” бичлэгээс Түүний уянгалаг хоолойг сонсоно уу.*

Сайхан нойрсоорой, үзэсгэлэн гоо минь,  
тавтай амраарай, сүр жавхлан минь.

Санаж яваарай, Бурханы үр сад юм шүү, та нар!  
Сайхан зүүд зүүдлээрэй, сайн найзууд минь,  
Сацрах гуа үзэмж, Диваажингийн хайр минь!

Бурхан та нарт хичнээн хайртай билээ,  
би бас дутахааргүй хайртай.

Бурханы үр сад, Түүний хайр юм шүү, та нар!  
Сайхан амраарай, Диваажингийн хайр, сайн найзууд минь.  
Сүр жавхлан, миний гайхамшгууд юм шүү, та нар!

Таныг хайрлан энэрч, хүндэтгэн дээдэлж,  
Тэнгэр хамгаалж, Бурхан ивээдэг ээ.  
Хэлүүлэх юү билээ, би ч танд хайртай,  
Хэзээд хайр минь таных байсаан.  
Хонгорхон минь дээ, та бол Хурмастын үр сад,  
Хэзээ ч бүү март, Бурханы үр гэдгээ!

Та бол миний хайрладаг ганц минь аюу,  
Та бол Бурханы энэрдэг гагц нь буюу.

Санаж яваарай, та бол Хурмастын үр сад,  
Сүр жавхлан хийгээд Бурхан Тэнгэр ээ.  
Ямар ч үе бид нэг нэгэндээ үнэн хайртай,  
Яаж ч байсан бид үргэлж цугтаа.  
Хамгийн сайн найзууд аа, бид, аль ч төрөлдөө.  
Хагацаж хэзээ салахгүй ээ, бид, нэг юм чинь дээ.  
Учир нь бид нэг нэгэндээ хайртай,  
Утга нь Бурхан таныг өнө мөнхөд энэрдэг ээ.

Битгий март, бид Диваажингаас ирсэн юм аа,  
Бид бүхэн нэг л өдөр Гэрээдээ буцах болно.  
Бидний унаган гэрт гуниг харуусал гэж үгүй ээ,  
Билиг төгс сайн сайхан л тэнд цогцлон байдаг аа.  
Энэрэл хайр, энх амгалан, баяр жаргалан, сүр жавхлан,  
Энэ бүхэн л тэнд найрсан байхаас энэлэн шаналан огоот үгүй!  
Ямар ч харуусал гуниг яаж ч зовоохын шалтгаан үгүй ээ.  
Яагаад гэвэл та Бурханы хайр, сац бас миний хайр аа!

Умартаж магадгүй ээ, та, санах нь гэвч дамжиггүй.  
Учир нь гэвэл та Бурханы үр сад, гайхамшгийн цогц!

Утга нь гэвээс та шилдэгийн шилдэг,  
Ургуулаад бодвол Бурханы хайрладаг цорын ганц!  
Өдөр бүр таныг би улам илүүтэй хайрлана,  
Өөр юу ч миний хайрыг өөрчилж үл чадна!

Зөн билгээр хараалж, сайхан зүүд зүүдлээрэй,  
Зорин очоорой Диваажинг, зочлон ороорой, Гэртээ.  
Тэнд л бид байхын учиртай, тэнд л бид оршихын утгатай.  
Түгшүүр төрөм, аймшигт ертөнц огоот тэр бус аа.

Бид нэг л өдөр элдэв бүхнийг ардаа орхино,  
Бид Диваажинд очиж, хайртай хамт оршино!  
Ахин хэзээ ч хагацал зовлонг үзэхгүй,  
Ахиад яасан ч уйтгар гунигт автахгүй!

Бүхий л зүйлс, ирж буцдагаас бус, энд буй.  
Бүхийлэн сэтгэлдээ амар амгаланг оршоо доо!  
Тэртээх нэгэн цагт Диваажин хэмээх  
Тэнгэрийн оронд амарлин байснаа санаж яв даа.  
Өөрийгөө өгөөмөр аз жаргалаар дүүрэн  
Гайхамшгийн цогц гэдгээ санаж яваарай!  
Өөрийгөө бас сүр жавхлан төгс  
Гоо үзэсгэлэнгийн биелэл гэдгээ бүү мартаарай!  
Та миний санаанд ив илхэн байнам,

Танаас гуйя, үүнийг санаж, жаргалтай яваач!  
Энэ ертөнцөд юу ч болсон яахав дээ,  
Эрт эдүгээ, ирээдүй хойтод ивгээгдэхээс хойш.  
Учир нь гэвээс та хүмүүн заяат биш ээ,  
Утга нь гэвэл бид махан бод бус аа.  
Та ердөө л үүнийг мартаж орхиж,  
Танаас дахин гуйя, санаж сэхээрч үз дээ!  
Тэгвэл та амарлингуй болно,  
Тэгэж гэмээ нь жаргалтай явна.

Бүү март, Бурханы үр шүү дээ, та!  
Бурханы хайр, сац бас миний хайр,  
Сайтар санаж ав, Бурханы хайр юм шүү, та!  
Сайхан бүхэн, гайхамшиг болгон танд буй.

Сайн мэднээ, би үүнийг.  
Санаж явахыг л хүснэ, би танаас!  
Хамгийн шилдэг нь гэдгээ бүү март,  
Үнэнийг танд хэлж байна, үүнд итгэ.  
Харамсалтай нь “би” гэх бодол таныг доройтуулжээ,  
Үнэн Мөн Чанар тань энэ биш юм, гайхамшиг шүү дээ, та!  
Та бол дэндүү ариун,  
Чин сэтгэл цогцолсон хайр билээ л!

Үнэндээ хэн бэ гэдгээ мэдэхийг чинь л би хүснэ,  
Үүрд зовлонгоос ангижирч, жаргалтай болноо, тэгвэл!  
Учир нь таныг сайны цогц гэдгийг би мэднэ.  
Ухааран сэхээрч миний замналаар яваасай хэмээн хүснэ.

Тэгвэл зовлон бүхнээс чөлөөлөгдөнө, та.  
Тэгэж гэмээ нь бас гуниг харуулаас ангижирна.  
Танд би хичнээн хайртай билээ,  
Таныг би дагуулан замнахыг хүснэм!

Нэг л өдөр та... хэн гэдгээ мэднэ.  
Нээрээ л хайр хийгээд цэвэр ариуны цогц,  
Бурханы үр сад, Тэнгэрийн хүүхэд,  
Бүх Диваажингийн хайр юм гэдгээ мэдэрнэ!

Миний мэдэж байгааг та мэдээсэй,  
Бурхан таныг хайрлаж буйг хараасай!

Магадгүй та ганцаардалд автаж гэмээ нь  
Бодлын чинь буруу шүү, дээдийн хайр минь!  
Үргэлж дэргэд чинь байж, Бурхан таныг хардаг юм,  
Үүрдийн их хайраараа таныг ивгээж явдаг юм!

Миний мэддэг замыг та ч бас мэдээсэй,  
Хоног өдрийн алинд ч Бурханы хайрыг хараасай!  
Миний мэддэгийг та мэдээсэй хэмээн хүснэ,  
Тэгэж гэмээ нь та харуусал гунигаас чөлөөлөгдөнө!

Миний мэддэгийг та нэг л өдөр мэдэх буй за,  
Тэгвэл хэн ч таныг айдаст автуулж чадахгүй!  
Тэр үед хэн ч таныг ахин шархлуулж дөнгөхгүй!  
Тийм өдөр ирж, бүхнийг та олж мэдэхэд  
Өр зүрх чинь үүрд амар амгалан болно!  
Өөрийгөө хэн бэ гэдгээ санахуйяа  
Өнө үүрд та чөлөөлөгдөнө.  
Миний мэддэг замыг та ч бас мэдээсэй,  
Тэр л өдөр тохиоход Бурханы хайрыг хараасай!

Сайхан зүүд зүүдэлж, Бурханыг санаарай,  
Сайхан зүүд зүүдэлж, Бурханыг санаарай!  
Та Тэнгэрийн үр, Бурханы хайр,  
Та миний хайр гэдгээ бүү мартаарай...(!)



## *Аятай Тавтай Амраарай, Алдрай Мину*

*Энэхүү бүүвэйн дууг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай шавь нартаа болон хайртай амьтаддаа зориулан, хамаг төрөлтөнд Бурханыг үүрд санаж явахыг айлтган толилуулжээ. CD M037-д буй “Аятай тавтай амраарай, алдрайхан мину” бичлэгээс Түүний уянгалаг хоолойг сонсоно уу.*

Аятай тавтай амраарай, алдрай мину,  
Агуу гайхамшгийн зүүд зүүдлээрэй.  
Асар Тэнгэр чамд хайртай,  
Аяа, би ч чамд хайртай.

Бурханыг санан дурсаарай,  
Тэр чамд үнэхээр хайртай.  
Бурханы үр сад юм шүү, чи.  
Түүний хүүхэд мөн шүү, чи.

Сайхан амраарай, үзэсгэлэн гоо минь,  
Түүнийг дурсан бодоорой,  
Саруулхан гэрлийг төсөөлөөрэй,  
Тэнгэрлиг Хайрыг санаарай.

Хамтдаа бид амьдралыг сайхан болгоно,  
Хамтдаа бид биесээ хайрлах болно.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
2009 оны 7-р сарын 18,  
Франц, Гэгээн Мартин төв

Унт даа, унт, хонгорхон минь.  
Уйтгар хийгээд зовлонгоос ангид  
Дээдийн дээд ертөнцөд уулзъя.  
Диваажин бидний дотор бий шүү.

Сайхан амраарай, солонгохон минь,  
Бурханы хайранд нойрс.  
Сахиулсан тэнгэрийн алган дээр,  
хөвөн зөөлөн үүлсийн дунд,  
Ай түмэн дуучийн эгшиг  
аялгуунд бүүвэйлэгдэн,  
Алсын чанад ертөнцийн ариун  
Гэгээнд нойрс доо.

Өдрөөс өдөрт чамайг би улам  
ихээр хайрлана.  
Тэнгэр элч нар чамайг хамгаалж,  
Бурхан адислана.  
Чи бол Хурмастын үр сад,  
Бурханы хүүхэд,  
Чи бол Хурмастын үр сад,  
Бурханы хүүхэд ээ.

Амар даа, амар, алдрайхан минь.  
Аяа, чи Хурмастын үр сад аа.  
Тэнгэрийн зүүд, Бурханы хайранд  
Тавтай сайхан нойрс доо.

Амар даа, амар, үзэсгэлэн гоо минь,  
Анд сайн найзууд минь.  
Тэнгэрийн зүүд, миний хайранд  
Тавтай сайхан амар даа.  
Бид Бурханы үр сад,  
Бид ариунаас ариун,  
Бид Бурханы хайр  
Бүү март, үүнийг хэзээ ч!

Тавтай амар даа, хонгор үрс минь,  
Тансаг үзэсгэлэнт, Бурханы  
гайхамшигт бүтээлүүд минь.  
Хайранд тань, хамт байгаад  
тань баярлалаа,  
Халуун сэтгэлд тань, үнэнч занд  
тань гялайлаа.  
Хоног өдрийн алинд нь ч та нарыгаа  
хайрладаг минь үнэн,  
Хосгүй хайраа эгнэгт тандаа өргөх  
минь ч үнэн!

Бурханыг хийгээд өөрийн аугаа  
Мөн Чанараа санагтун.  
Диваажин та нарт хайртай,  
аяа, би ч та нартаа хайртай.  
Билгүүн үзэсгэлэнт, сайхан найзууд  
минь, амар даа.

Сүр жавхлант зөн билгийн зүүдэнд  
тань уулзалдая.  
Бидний л төлөө наран манддаг билээ,  
Сайхан амарч, сайн зүүд  
зүүдлээрэй!

Нойрын сайханд умба даа, хонгор  
минь.  
Надтай хамт байвал айх юм чамд  
үгүй,  
Асгарах бороо ч цутгах нь үгүй,  
Аянга цахилгаан ч цахилах нь үгүй  
ээ.

Диваажин чамайг ивгээнэ,  
Тэнгэр элч нар ч бас хамгаална.  
Тиймээс чи энэлж шаналахгүй,  
Тэнгэрлиг мөнхийн хайранд  
умбанаа.

Хүйтэн зэвсгийн хөнөөлийг  
холдуулж,  
Хахир цахилгааны аюулыг  
зайлуулж,  
Харанхуй шөнийг амарлиулах гэж,  
Харин би энд байна.

Миний сайн хөвгүүд,  
Миний сайхан охидод  
Юу ч тохиолдохын учиргүй.  
Юун гэвэл та нар Бурханы хайр аа.

Үүлсийн дээгүүр,  
Хурмастын цаагуур  
Оддын дунд бүжиглэж,  
Тэнгэр элч нартай цуг дуулцгаа даа.

Өдөр өнгөрөх бүрийд  
Өөрсдийг тань би туйлаас их  
хайрладаг.  
Диваажин та нарыг хамгаалж,  
Бурхан энэрэн ивгээж,  
Тэнгэр элч нар магтан дуулж,  
Шидэт дагинас бишрэн дээдэлдэг ээ.  
Хажуу дэргэдийн бүхэндээ  
Халуун инээмсэглэл төрүүлдэг,  
Аялгуу дуугаараа та нар минь  
Ашдын өдрүүдийг минь цогцлоодог  
оо.

Амарцгаа даа, амарцгаа,  
Аяа, миний нандинхан эрдэнэс мину.  
Алаг солонгын зөн билиг төгс  
Аятай сайхан нойрсцгоо доо.

Хонгор минь, чамд баярлалаа.  
Хосгүй их хайр,  
Хоёргүй үнэнч сэтгэл,  
Ховорхон нандин зүрхэнд чинь  
гялайлаа.

Энхрийхэн минь,  
Эгэлгүй ихээр хайрлаж,  
Энэрэн ойлгосонд чинь  
Энгүй ихээр гялайлаа.

Баярлалаа, энхрийхэн минь,  
Бялхам хайр,  
Бахархам үнэнч сэтгэлд чинь  
Баярлалаа.

Чи хүмүүний ертөнцөд илгээгдсэн  
Чинхүү Бурханы илгээлт.  
Хурмастын энэрэлд умбасан  
Хайрын гэгээн биелэл ээ.

Царай зүсий минь гийгүүлсэн  
Цайлган инээмсэглэлд чинь  
баярлалаа.  
Өнө мөнхөд хайр цацруулсан  
Өгөөмөр зүрхэнд чинь гялайлаа.

Анд нөхрөө хамгаалсан  
Тэнгэр элч ээ, чи.  
Ариун шударгыг өмгөөлсөн  
Аймшиггүй баатар аа, чи.

Эргэх нэгэн цагийн  
Эгнэшгүй найз чамаараа бахархнам.  
Энэрэл хайрыг чинь хүлээсэндээ  
Элэг зүрх минь баяснам.

Хонгор минь, сайхан амраарай,  
Хотол Диваажин чамайг хамгаалж,  
Хүчирхэг Бурхан чамайг ивгээдэг.  
Хайраа ч би чамдаа зориулдаг аа.

Чиний хайр энэрэл,  
Чин үнэнч сэтгэлд чинь баярлалаа.  
Чиний ялдам төрх,  
Чинхүү ариун зүрхэнд чинь  
гялайлаа.

Чи – миний эрдэнэ,  
Чи – миний эрдэнэс,  
Чи – миний тайтгарал,  
Чи – миний үзэсгэлэн.



Чи над баяр баяслыг бэлэглэдэг,  
Чи над хайр энэрлийг түгээдэг,  
Чи над хүч чадлыг хайрладаг,  
Чи над итгэл найдварыг өгдөг өө.

Саран мэт туяат,  
Наран мэт гэрэлт  
Сайн найз минь,  
Надтай хамт өнөд байгаач.

Амар даа, амар, алдрайхан минь,  
Аяа, миний үзэсгэлэн гоо минь.  
Дээдийн дээд гайхамшигт найзууд  
минь,  
Диваажингийн их хайр энэрэл минь.  
Амгалан сайхан зүүд зүүдлээрэй,  
Асар Тэнгэрийн үр сад мину,  
Авралт Бурханы хайр мину,  
Аяа, миний эрдэнэс мину.

Амар даа, амар, алдрайхан минь,  
Асар Тэнгэрийн үр сад мину,  
Авралт Бурханы энэрэл мину,  
Аяа, миний хайр мину.  
Диваажин чамайг ивгээж,  
Дээдийн Бурхан чамайг адисладаг  
аа.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
2009 оны 10-р сарын 18,  
Франц, Роквэбрюн





## *Ахин учрах маань хэзээ вэ?*

*Эх бичвэр Ау Лак хэл дээр: "Bao Giò Găp Lai?"*

Аяа, хонгор минь, ахин учрах маань хэзээ вэ?  
Амраг бидний мөнхийн хайр өнө эргийн тоосонд дарагдаа юу?  
Алс тэртээх амьдралдаа хайрын андгай өргөсөн сөн,  
Аниргүй саран гэрчилнэ дээ, ай гэвч харгуй зам маань баларч дээ.



Аяа, амраг минь, алсын алс ертөнцөд  
Ахин Тэнгэрийн Заадсаар учрах өдрөө хүлээнэ үү?  
Тэртээх нар саранд оргилуун сэтгэлээр залбиравч  
Түрхэн зуурын ертөнцөд сүнс чинь алдууран одож дээ.

Цаглашгүй тэнгэртээ түгэх од мичдийн гялбаа шиг,  
Цаг үргэлжид цэнхэртэх асар их усан мэт,  
Өнгө гайхуулан сацрах ялгуусан гариг адил  
Өнөд миний сэтгэл үнэн чанарыг чинь үгүйлнэм.

Аяа, амрагхан хайр минь, дөрвөн зүгтээ итгэлийн долгис цацалж,  
Ахин учрах мөчийг би угтанхан хүлээнэм.  
Өр зүрх минь төөрөг заяаг огоорон найдвараар цохилж,  
Өнгийн аялгуу уруул даван сацарнам.

Үнэгэн харанхуй нөмрөвч, үүрийн туяа гэгээрдэг.  
Гүн нойрноо умбавч үлгэрийн зүүднээс сэрдэг.  
Аялгуут далайн чимээнд Диваажингийн салхин сэвших  
Амгалан гэгээн ертөнцдөө эгэн бид очноо.



Яруу найрагчийн авсан гэрэл зураг

## Дуулагдсан Улун Найргууд

Эрин зууны хайр яруу найргийн цомирлогт багтсан олон шүлэг найрагт хөгжмийн алдартай зохиолч нар ая бичсэн ба Суприм Мастер Телевизийн Гоо зүйн ертөнцөөр аялахуй: Хөгжим ба яруу найраг нэртэй нэвтрүүлэг болон тус телевизийн ойн баярын концертуудад тоглогдсон билээ. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай болон алдарт уран бүтээлчдийн яруу найраг, дуунуудыг дараах хаягаар нэвтэрч таалан сонирхоцгооно уу.

- HAY BUNG TINH! (PLEASE WAKE UP!): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=129&page=1#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=129&page=1#v)
- HAY DUNG LAI! (PLEASE DON'T!): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=129&page=1#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=129&page=1#v)
- VE THU HO (TO THU HO): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=51&page=6#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=51&page=6#v)
- NHA TOI (MY HOME): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=138&page=1#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=138&page=1#v)
- GOI LE UYEN PHUONG (FOR LE UYEN PHUONG): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=106&page=3#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=106&page=3#v)
- KHONG DAU EM (IT IS NOT SO, MY LOVE): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=141&page=1#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=141&page=1#v)
- GOI THAI HANG (FOR THAI HANG): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=113&page=3#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=113&page=3#v)
- CHO PHAM DUY (TO PHAM DUY): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=113&page=3#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=113&page=3#v)
- MO DEM (DREAM IN THE NIGHT): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=72&page=5#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=72&page=5#v)
- KHUAT NHO THOI GIAN (SHADE OF TIME): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=59&page=6#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=59&page=6#v)
- LOI LON CON (WORDS OF A PIGLET): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=131&page=1#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=131&page=1#v)
- LOI GA MAI (WORDS OF A HEN): <http://www.suprememastertv.com/mp/?page=7>
- LOI CHU VEN (A PUPPY'S HEART): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=45&page=6#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=45&page=6#v)
- SAYONARA: [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=120&page=2#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=120&page=2#v)
- DOA SEN VANG (THE GOLDEN LOTUS): [http://www.suprememastertv.com/mp/?wr\\_id=120&page=2#v](http://www.suprememastertv.com/mp/?wr_id=120&page=2#v)
- Ngoi Ca va Chuc Mung (Praised Be the Providence): <http://www.suprememastertv.com/3year>
- MƠ ĐÊM (Dream in the Night), Thương Nhau Đi (Let's Love), and When You Said You Khi Người Nói Yêu Ta (Love Me): <http://www.suprememastertv.com/4year>

Уоморлигт орсон шүлэг найргууд “Шөнийн зүүд”, “Цагийн сүүдэр”, “Алтан лянхуа”, “Аятай тавтай амраарай, алдрай мину” зэрэг сүүлд хэвлэгдсэн CD болон DVD-ийнд багтсан буй. Эдгээр CD болон DVD –г худалдан авч, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ялдам уянгалаг хоолой, сэтгэл хөдөлгөсөн уншилгаар сонороо мялаан баясья гэвэл холбоо барих дараах хаягуудаар зочилно уу. Үүнд:

- CD-M036, DVD 801 – Хаа Эртгийн Хайр: Цаглашгүй хайр; Thu Hó танаа; Миний гэр; Хаа эртгийн хайр; For Lê Uyên Phương; Хайрлацгаая; Үгүй дээ, хайр минь; Буддагийн чулуун хөшөөтэй ярилцсан мину; Тэр л өдөр; Thái Hằng танаа; Phạm Duy танаа; Мөрөөдлийн зун.
- CD-M030, DVD 764 – Шөнийн Зүүд: Шөнийн зүүд
- CD-M031, DVD 765 – Цагийн Сүүдэр: Цаг хугацааны сүүдэр
- CD-M035, DVD 770 – Алтан Лянхуа: Саёнара, Алтан лянхуа
- CD M037 – Аятай Тавтай Амраарай, Алдрай Мину: Аятай тавтай амраарай, алдрай мину, Бурхан чамд хайртай!

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Шүлгийн цоморлиг



• Энэ Өдөр, Тэр Өдөр  
(Ау Лак хэлээр уншсан шүлгүүд): CD



• Анхилам сайхныг мэдрэхүй  
(Алдарт дуучид Ау Лак хэл дээр дуулсан): CD



• Үүрд хадгалаарай:  
(Ау Лак хэл дээр уншсан шүлгүүд): CD



• T-L-C, Гуйя  
(Ау Лак хэл дээрхи дуу): CD



• Аятай тавтай амраарай, алдрай мину:  
(Англи хэл дээр дуулсан дуунууд) CD



• Цагийн сүүдэр  
(Ау Лак хэл дээрхи дуунууд): CD ба DVD



• Хаа эргийн хайр  
(Ау Лак хэл дээрхи дуунууд): CD ба DVD



• Шөнийн зүүд  
(Ау Лак хэл дээрхи дуунууд): CD ба DVD



• Алтан лянхуа (Ау Лак хэлээр уншсан шүлгүүд): CD ба DVD

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийн бичсэн “Алтан лянхуа” “Саёнара” гэсэн хоёр шүлгээ уншина. “Их Багш уянгалаг хоолойгоороо эрхэмсэг Thich Man Giac-ийн гайхамшигт шүлгийг дуудна”. Таалан сонсоорой!



• Хайрын домгийн зам:  
(Ау Лакын алдарт яруу найрагчдын шүлгүүд, Аулак хэлээр уншсан шүлгүүд): Аудио хуурцаг, CD 1,2 & 3 DVD 1,2



• Өмнөх амьдралын зам мөр:  
(Ау Лак хэлээр уншсан шүлгүүд): Аудио хуурцаг, CD 1,2 & 3 DVD 1,2 (17 хэлний хадмал орчуулгатай)



• Эрдэнэсээр хэлхсэн шүлгүүд  
(Ау Лакын алдарт яруу найрагчдын шүлгийн Ау Лак хэл дээрхи уншилт): CD 1,2; DVD 1,2



• Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн өөрөө зохиосон дуу, хөгжмүүд:  
(Англи, Ау Лак, Хятад хэлээр)



• Хайрын дуу  
(Англи, Ау Лак хэл дээрхи дуунууд) DVD




• **Хайрга ба Алт:**  
Англи, Ау Лак, Хятад  
хэл дээр



• **Өмнөх амьдралын зам мөр:** Англи, Ау Лак, Хятад хэл дээр



• **Эрвээхэйн мөрөөдөл:**  
Ау Лак, Хятад, Англи хэл дээр



• **Мартагдсан дурсамж:**  
Ау Лак, Хятад, Англи хэл дээр



• **Эрт дээр үе:**  
Ау Лак, Хятад, Англи хэл дээр



• **Wu Tzu-н яруу найраг:**  
Ау Лак, Хятад, Англи хэл дээр



• **“Эрин Зууны Хайр”:**  
Ау Лак, Хятад, Англи хэл дээр



• **Чимээгүй нулимс:**  
Их Багшийн шүлгийн ном - Англи/Герман/Франц, Англи/Хятад, Ау Лак, Испани, Португаль, Солонгос, Филиппин хэл дээр

## ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ОЮУН САНААНЫ СУРГААЛ, НОМЛОЛУУД

### НОМУУД

- **“Агшин Зуур Билэг Нээгдэхүйн Түлхүүр”:**  
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн лекцийн эмхэтгэл. Ау Лак (1-15), Хятад (1-10), Англи (1-5), Франц (1-2), Финн (1), Герман (1-2), Унгар (1), Индонейз (1-5), Япон (1-4), Солонгос (1-11), Монгол (1,6), Португали (1-2), Польш (1-2), Испани (1-3), Швед (1), Тай (1-6), Төвд (1)
- **“Агшин Зуур Билэг Нээгдэхүйн Түлхүүр” - “Асуулт, Хариулт”**  
Их Багшийн лекцийн асуулт хариултын эмхэтгэл. Ау Лак (14), Хятад (13), Болгар, Чек, Англи (12), Франц, Герман, Унгар, Индонез (13), Япон, Солонгос (14), Португали, Польш, Орос (1), “Долоон өдрийн даяан” тусгай хэвлэл, 1992 он, Англи, Аулак хэл дээр гарсан.
- **“Агшин Зуур Билэг Нээгдэхүйн Түлхүүр”-**  
Тусгай хэвлэл/Дэлхийг тойрсон аялал, Англи (16) Хятад (16)
- **“Багш шавийн харилцсан захидал”**  
Англи (1), Хятад (13), Ау Лак(12), Испани (1)
- **Их Багшийн гайхамшигт баясахуй:**  
Ау Лак (12), Хятад (12)
- **“Багш үлгэр ярьж байна”:**  
Англи, Хятад, Испани, Ау Лак, Солонгос, Япон, Тай хэл дээр хэвлэгдсэн.
- **Амьдралаа өнгөлөг болгохуй:**  
Хятад, Англи, Ау Лак хэл дээр хэвлэгдсэн.
- **Бүх юмыг сайтар халамжил - Их Багш Чин Хайн Мэргэн ухааны Үлгэрүүд:**  
Ау Лак, Хятад, Англи, Франц, Япон, Солонгос хэл дээр хэвлэгдсэн.
- **Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч Хошигнол –Таны Гэрлэн бүрхүүл дэндүү давчуу байна!**  
Англи, Хятад хэл дээр хэвлэгдсэн.
- **Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд:**  
Хятад, Англи, Ау Лак хэл дээр хэвлэгдсэн.
- **Эзэн Бурхантай шууд холбогдох - Энх тайванд хүрэх зам:**  
Англи, Хятад хэл дээр хэвлэгдсэн.
- **Бурханых ба Хүн төрөлхтөнийх - Библийн үлгэрүүдээс:**  
Англи, Хятад хэл дээр хэвлэгдсэн.
- **Эрүүл мэндийг ухаарахуй – Амьдралын жам ёсны бөгөөд зөв замд буцаж орох нь:**  
Хятад, Англи хэл дээр хэвлэгдсэн.
- **Гэрт чинь хүргэж өгөхөөр би ирлээ:**  
Араб, Аулак, Болгар, Чех, Хятад, Англи, Франц, Герман, Грек, Унгар, Индонез, Итали, Солонгос, Монгол, Польш, Испани, Түрэг, Румын, Орос хэл дээр хэвлэгдсэн.

• **Онч мэргэн үг:**

Англи/Хятад, Испани/Портулаги, Франц/Герман хоёр хэлээр, мөн Солонгос хэл дээр хэвлэгдсэн.

• **Тэнгэрлиг зоог (1):** Олон улсын цагаан хоолны гал тогоо:

Англи/Хятад хэлээр, Ау Лак, Япон хэл дээрх эмхтгэл.

• **Тэнгэрлиг зоог (2):** Гэрийн хоолны амтат сонголт

Англи, Хятад хэлний нэгтгэсэн эмхтгэл

• **Дуу хөгжмөөр энх тайван, эв нэгдэлд хүрэхүй:**

Англи/Ау Лак/ Хятад хэл дээр хэвлэгдсэн.

• **Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлиг:**

Англи, Ау Лак, Хятад хэл дээр хэвлэгдсэн.

• **SM Тэнгэрийн хувцас:**

Англи, Хятад хэл дээр хэвлэгдсэн.

• **Миний амьдрал дахь ноход:**

Ау Лак, Хятад, Англи, Япон, Солонгос, Испани, Польш, Герман хэл дээр хэвлэгдсэн.

• **Шувууд миний амьдралд:**

Ау Лак, Хятад, Англи, Франц, Герман, Монгол, Орос, Солонгос, Индонез хэл дээр хэвлэгдсэн.

• **Эрхэм ариун амьтад:**

Ау Лак, Хятад, Англи, Франц, Герман хэл дээр хэвлэгдсэн.

• **Тэнгэрийн Урлаг:**

Хятад, Англи хэл дээр хэвлэгдсэн.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн лекц, хөгжим, концертын аудио, видео хуурцгууд, MP3, CD, DVD –үүд Араб, Армени, Ау Лак, Болгар, Камбож, Кантонец, Хятад, Хорват, Чех, Дани, Голланд, Англи, Фин, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Мандарин, Монгол, Непал, Норвег, Перс, Польш, Португал, Румын, Орос, Сингал, Словак, Испани, Швед, Тай, Турк, Зулу хэл дээр хэвлэгдсэн байдаг. Таны хүсэлт тавьсаны дагуу жагсаалтыг илгээх болно. Асууж лавлах зүйл байвал чөлөөтэй хандана уу. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүүлийн үеийн ном хэвлэлийн товч мэдээ, жагсаалтыг татаж авах хүсэлтэй бол манай номын дэлгүүрийн вэб хаягаар зочлоорой: <http://www.smchbooks.com/> (Англи ба хятад хэлээр буй.)

**ЗАХИАЛАХ ХАЯГУУД:**

<http://www.theCelestialShop.com>

<http://www.EdenRules.com>

**ЭСВЭЛ ДАРААХ ХАЯГААР ХОЛБОО БАРИНА УУ:**

Tel: (886) 2-87873935 / Fax: (886) 2-87870873

E-mail: [smchbooks@Godsdirectcontact.org](mailto:smchbooks@Godsdirectcontact.org)

**ROC Postal Remittance Account No.: 19259438**

(Зөвхөн Формосагийн захиалга)

**Илгээмжийн Хаяг:**

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани, ХХК


• **Эрхэм Ариун Амьтад** 5 дугаар Алтан жилийн оны (2008) босгоор амжилттай алхахуй дор Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дэлхийн хүн төрөлхтөнд шинэ жилийн баярын бэлэг болгон “Эрхэм ариун амьтад” номыг өргөн барьсан билээ. Их Багш өөрөө гэрэл зургуудыг нь авч, зохиомжилсон энэ номын хуудаснаа Тэр бээр нуур хавиар илрүүлсэн нээлтүүдээ гайхамшигтай яруу шүлгээр илэрхийлж, шидэт байгаль, хээрийн амьтдын зургаар чимэглэсэн нь энэ номыг урлагийн хосгүй бүтээл болгосон билээ.

**Amazon.com дахь хаяг**

<http://www.amazon.com/Noble-Wilds-Supreme-Master-Ching/dp/9868415233/> (paperback)

<http://www.amazon.com/Noble-Wilds-Supreme-Master-Ching/dp/9868415225/> (hardcover)

Эрхэм Ариун Амьтад  
DVD #800 (Англи хэл дээр 21  
хэлний хадмал орчуулгатай)



• Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн бичсэн “Шувууд Миний Амьдралд” хэмээх өнгө будаг үзэсгэлэнтэй сайхнаар хосолсон ном нь амьтдын дотоод ертөнцөд биднийг урин залдаг билээ. Бид хариу нэхэлгүй хайрлахад тэд бидэнд зүрх сэтгэлээ ямар ч саадгүй нээдэг билээ. Хуудас бүрээс нь хайр, эв найрсал сацарсан энэ гайхамшигтай номоороо Төгс гэгээрсэн Их Багш маань бидэнд амьтад маш ариун бөгөөд үзэсгэлэнтэй сайхан сүнстэй гэдгийг ойлгуулдаг юм. Ямар гайхамшигтай ном гээч! Амьтад бол хүмүүс бидний сайн анд нөхөр. Хүн бүр энэ гайхамшигт номыг авч уншина уу.

**Amazon.com дахь хаяг**

<http://www.amazon.com/dp/9866895149/>

Have it delivered to your door and begin experiencing the love flowing on the pages.

Номыг гэртээ хүргүүлээд хуудас бүрээс нь урсан гарах хайрыг мэдрээрэй!

• **Миний Амьдрал дахь Ноход (1-2)**

“Ноход бидэнтэй зэрэгцэн Газар дэлхий дээр ямар үзэсгэлэнтэй сайхан мөр үлдээдгийг уншигчид маань зэрвэс ч болов мэдэрч баясаасай, тэднээр дамжуулж бусад төрөлтнүүдийн тухай улам ихийг ойлгож мэдээсэй гэж хүснэм.”

~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Amazon.com дахь хаяг:

Миний амьдрал дахь ноход 1): <http://www.amazon.com/dp/9866895076/>

Миний амьдрал дахь ноход (2): <http://www.amazon.com/dp/9866895084/>

(Хятад хэл дээр)


Кингстоун Онлайн Номын дэлгүүр: <http://www.kingstone.com.tw>

Эслитэбүүкс Онлайн Номын дэлгүүр: <http://www.eslitebooks.com/>

Бүүкс Онлайн Номын дэлгүүр: <http://www.books.com.tw>

**МИНИЙ АМЬДРАЛ ДАХЬ НОХОД БА  
ШУВУУД МИНИЙ АМЬДРАЛД  
DVD #780**

(Англи хэл дээр 28 хэлний хадмал орчуулгатай.)



**Тэнгэрийн Урлаг**

Тэнгэрийн урлаг бол уран бүтээлч өөрөө урлагийн бүтээлийг Үнэн, буян, Тэнгэрийн гоо үзэсгэлэнгээр илэрхийлэн оюун санааны өнцгөөс тайлбарласан онцгой гайхамшигтай боть билээ. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн хязгааргүй ертөнцөд нэвтэрч, тэнгэрлиг хэмнэлд нь автан дээшилсэн уншигч бүхэн яруу найрагчийн гүн мэдрэмж, уран зураачийн далд хүрэлцэхүй, загвар зохиогчийн өвөрмөц санаа, хөгжимчний оргилуун зүрх сэтгэлийг мэдэрч, сэтгэлийн эмзэг утас нь хөндөгддөг билээ. Юу юунаас илүү уншигч хүмүүн хэн боловч оюун санааны аугаа их багшийн билэг оюун, энэрэл нигүүлслийн адислалыг хүртэх нь гайхамшигтай.

AMAZON.COM дахь хаяг:

<http://www.amazon.com/Celestial-Art-Supreme-Master-Ching/dp/9866895378>

# Өөрөөр Амьдарцгаая

Эрүүл, тэжээлдэг бөгөөд амьтны амь таслаагүй хоол хүнсний жишээ:

| Хүнсний бүтээгдэхүүн                                          | Жинд эзлэх уургийн хэмжээ %-иар |
|---------------------------------------------------------------|---------------------------------|
| Дүфү (шар буурцагны бислаг)                                   | 16 %                            |
| Гурилмаас гаргасан уураг буюу глютин                          | 70 %                            |
| Эрдэнэ шиш                                                    | 13 %                            |
| Будаа                                                         | 8.6 %                           |
| Шар буурцаг, хүрэн буурцаг вандуй, гэх мэт                    | 10 - 35 %                       |
| Бүйлс, хушга, хэшүү, хушны самар                              | 14 - 30 %                       |
| Хулууны үр, сезаме буюу гүнжидийн үр, наран цэцгийн хар самар | 18 - 24 %                       |

Түүнчлэн олон төрлийн шахмал үрлүүд (мультивитамин) нь амин дэм, эрдэс бодис, хэт исэлдлийн эсрэг бодисын хангалттай эх үүсвэр юм. Жинс болон хүнсний ногоо нь амин дэм, эрдэс бодис, хэт исэлдлийн эсрэг бодисуудаар тун баялаг бөгөөд эрүүл саруул, урт удаан амьдралыг тэтгэгч сайн чанарын эсэлгүүдийг агуулж байдаг. Насанд хүрсэн хүний хоногт хэрэглэх уургийн дундаж хэмжээ: 50 гр Ургамлын гаралтай кальци нь үнээний сүүнийхээс илүү шингэцтэй.

- Дэлхий нийтэд эвэлхийлж буй шувууны ханиадны халдварт тархалтыг арилгах
- Үхрийн галзуу (BSE), гахайн өвчин (PMWS) гэх мэт өвчний аюулыг зайлуулах,
- Энхрийлж өсгөсөн мал сүрэг, гэрийн тэжээвэр болон лусын амьтад, эдгэн жигүүртэн энд нөхдөө тэрбум тэрбумаар нь хэрцгийлэн хороож буй явдлаа эцэс болгохын төлөө

**Мацаг хоолтон болох нь марган зая алхам юм.**

Ингах нь эрүүл мэндэд тустай.  
Ингэй нь эдийн засагт хэмнэлттэй.  
Ингах нь байгаль орчинд ээлтэй.  
Энэ бол амьдрал нийгүүлсэл.  
Энэ бол энэ амгалан.  
Энэ бол эрхэм зорин явдал юм.

Бидний амийг хэлрүүлээр! Бид Та нэрт хайртай

Бид Та нарыг төлөө залбирдаг шүү

**Энэрэнгүй сэтгэд таны баярлаг**

Холбогдох бусад мэдээллийг дараахь хаягаар авна уу

<http://AL.Godsdirectcontact.org.tw>  
<http://www.vegsource.com>  
<http://www.vrg.org>

эсвэл энэ хаягаар захиа бичээрэй: [AL@Godsdirectcontact.org](mailto:AL@Godsdirectcontact.org)

**Төгс Гэгээрсэн Их Багшийн Телевиз**  
 Энх амгалан ертөнцийн төлөө зөв ач тустай хөтөлбөр

Дэлхий даяар хиймэл дагуулын 14 станц болон интернетээр дараахь [www.SupremeMasterTV.com](http://www.SupremeMasterTV.com) хаягаар дэлхий дахинд цацагдаж байна. Galaxy 19, Hispasat 1C, Intelsat 805, ABS, Astra 1, AsiaSat 5, AsiaSat 3S, Sky TV, Intelsat 10 C-Band, Intelsat 10 KU-Band, Optus D2, Eurobird 1, Eurobird 2, Hotbird 6

Та урт насларай!

## Гүн ухаантнууд ба оюун санааны удирдагч нар

- Гүн ухаантнууд, шашны болон оюун санааны удирдагчид** Парамаханса Угананда (Энэтхэг оюун санааны номлогч багш), Сократ (эртний Грекийн гүн ухаантан), Есүс Христ, Кунь (Хятадын гүн ухаантан), Шагжамуни Бурхан, Лууц (Хятадын гүн ухаантан), Ассисийн Гэгээн Франсис (Италийн Гэгээнтэн), Тич Нат Хань (Вьетнам лам, зохиолч), Еоги Махарашри Махеш (Энэтхэгийн гүн ухаантан, зохиолч, трансэнденталь бясалгалын гэрлүүн), Лөв Николаевич Толстой (Оросын гүн ухаантан, зохиолч), Пифагор (эртний Грекийн гүн ухаантан, математик), Зороастер (Ираны Зороастрианизмыг үндэслэгч), Мухаммед Рахит Бава Мухаяадан (Шри ланкийн галын шашинт зохиолч), гэх зэрэг.
- Зохиолч, уран бүтээлч, зурвач нар** Леонардо Да Винчи (Италийн уран зураач), Ральф Уолдо Эмерсон (АНУ-ын нийтлэгч, яруу найрагч), Жорж Бернард Шоу (Ирландын зохиолч), Жон Робинс (АНУ-ын зохиолч), Марк Твейн (АНУ-ын зохиолч), Алберт Швейцер (Германы гүн ухаантан, эмч, хөгжимчин), Плутарх (Грекийн зохиолч), Садегх Хидаят (Ираны зохиолч), гэх зэрэг.
- Эрдэмтэн, зохион бүтээгч, инженерүүд** Чарльз Дарвин (Британий байгалийн ухаан судлаач), Алберт Эйнштейн (Германы эрдэмтэн), Томас Эдисон (АНУ-ын эрдэмтэн, зохион бүтээгч), Сэр Исаак Ньютон (Британий эрдэмтэн), Никола Тесла (Хрватгийн эрдэмтэн, зохион бүтээгч), Хэри Форд (АНУ-ын Форд Моторыг үүсгэн байгуулагч), гэх зэрэг.
- Улс төрч, төрийн зүтгэлтэн, нийгмийн идэвхтнүүд** Сюзан Б. Антони (АНУ-ын Эмэгтэйчүүдийн сонгуулийн эрхийн хөдөлгөөний удирдагч), Махатма Ганди (Энэтхэгийн иргэний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагч), Мартин Лютер Кинг ба түүний гэрлэгч (АНУ-ын иргэний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагчид), Жанез Дрновск (Словены Улсын Ерөнхийлөгч), Др. Манмохан Сингх (Энэтхэг Улсын Ерөнхий Сайд), Деннис Ж. Кучинич (АНУ-ын Конгрессын гишүүн), гэх зэрэг.
- Жүжигчид ба кино, телевизийн одод** Памела Андерсон (АНУ-ын жүжигчин), Ашли Жадд (АНУ-ын жүжигчин), Брижит Бардо (Францын жүжигчин), Жон Клийз (Британий жүжигчин), Давид Духовны (АНУ-ын жүжигчин), Данни Девиго (АНУ-ын жүжигчин), Дарил Ханна (АНУ-ын жүжигчин), Дастан Хофман (АНУ-ын жүжигчин), Стив Мартин (АНУ-ын жүжигчин), Иан МакКеллен (Британий жүжигчин), Тоби Магуайр (АНУ-ын жүжигчин), Жоакин Феоникс (АНУ-ын жүжигчин), Стивен Сигал (АНУ-ын жүжигчин), Жерри Сөйнфилд (АНУ-ын жүжигчин), Наоми Уэйтс (АНУ-ын жүжигчин, Кейт Уинслет (Британий жүжигчин), Кристи Бринкли (АНУ-ын супермодель), Кристи Турлингтон (АНУ-ын супермодель), гэх зэрэг.
- Поп одод, хөгжимчид** Жорж Харрисон - Поул Маккартни - Ринго Старр (Английн хөгжимчин, алдарт бийтлэгийн гишүүд), Боб Дилан (АНУ-ын хөгжимчин), Моррисей (Британий дуучин), Оливия Ньютон Жон (Британи-Австралийн дуучин), Шинед О'Коннор (Ирландын дуучин), Пинк (АНУ-ын дуучин), Принц (АНУ-ын поп од), Тина Түрнер (АНУ-ын од), Шанаа Твейн (Канадын дуучин), Ванесса Уильямс (АНУ-ын поп дуучин), гэх зэрэг.
- Спортснхон** Билли Джин Кинг (АНУ-ын тамирчин, теннисийн аварга), Карл Лүис (АНУ-ын хөнгөн атлетикийн тамирчин, Олимпын 9 удаагийн алтан медальт), Эдвин С. Мозек (АНУ-ын хөнгөн атлетикийн тамирчин, 2 удаагийн аварга), Александр Даргата (Германы тамирчин, Бодибилдингийн аварга, эмч), гэх зэрэг.

нэрсийг тооцоод барахгүй . <http://AL.Godsdirectcontact.org.tw/vg-vgp>



# Эрх Зүрхсэл Сайр

## Зохиогч

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

### Монгол Хэлнээ Орчуулсан

Дугарсүрэнгийн Гүн-Үйлс

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн Монгол дахь төвийн Номын баг

### Хянан Хэвлүүлсэн

Маналын Тэгшжаргал

### Хавтасны Загварыг Зохиомжилсон

Bie Lee

### Хавтасны Нэрийг Урлан Бичсэн

Гришаагийн Жааханхүү

### Уран Сайхны Зохиомжуудыг Бүрдүүлсэн

Diệp Quốc Vinh

### Зургуудыг Засварласан

Wang Bor Tang, Yu Hui-Chun

### Уран Бүтээлчидтэй Холбоо Тогтоосон

Formosa Taipei Center, Formosa Changhua Center,  
and Supreme Master Ching Hai International Association

### Гэрэл Зургуудыг Хандивласан

Supreme Master Ching Hai (Photos: Pages iv-v, x, xi, xii, xiii, xiv, xv, 1, 16, 17, 31, 76,  
77, 96, 97, 118, 154-165. Fan painting: Pages i & 168), Worldwide Photography Group,  
Supreme Master Television, Trần Đình Thục, Joshua Tan, Dreamstime Inc., DepositPhotos Inc., SXC.  
HUDF image (Pages 32-39): Courtesy of NASA, ESA, S. Beckwith (STScI) & the HUDF Team

## Хэвлэгч

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн

Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани, Тайвань, Тайпэй

<http://www.smchbooks.com>

Утас: (886) 2-87873935 / Факс: (886) 2-87870873

## Анхдугаар Хэвлэл

2011 Оны 1 Сар

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 2010

ISBN:

Бүх эрх хуулиар хамгаалагдсан

Хэвлэгчээс урьдчилан зөвшөөрөл авсны дагуу та энэ  
номын яруу найргуудыг дахин хэвлэж болно.



**Хөгжмийн зохиолч Trần Quang Lộc-ийн сэтгэгдэл:**

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найргууд нь хайранд уярсан сэтгэлээр дүүргэгдсэн торгомсог зөөлөн хэмжээсээр хөвөрдөг билээ. Түүний шүлгүүд түрхэн зуурын энэ хорвоод хүмүүний сүнсийг гүн бясалгалын цэнгэлд умбаастай Хурмастын оронд хүргэж өгөх хөтөч бамбар нь гэлтэй. Яруухан үгс нь тигэм-таван хөгт хөгжмөөр амьдралын арга билгийг сүлбэлдүүлж, шүүдрийн гялалзсан дусал мэт уянгалаг аялгууг эгшээх нь жинхэнэ ба зүүд, үзэгдэх ба үл үзэгдэхүй, зовлон ба жаргалын мөнхийн уран шигтгээ гэлтэй байдаг.

...Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Эрин Зууны Хайр цомирлогийн дөчин зургаан яруу найраг нь хүмүүний оюун санааны дотоод ертөнцийг төдийгүй гараг дэлхийг тэнгэртэй нь, ургамал амьтантай нь гэрэлтүүлэн гийгүүлдэг билээ. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн яруу найргийн хэмжээлшгүй урын санд нэвтэрсэн уншигч бүр “хүн ба байгалийн хоорондох хайрын” халуун дулаан хэлхээ холбоо, шүтэн барилдлагыг танин мэдэх нь лавтай.

*“Хайрт чамтайгаа эргээд нэгдэхсэн гэх дээ  
Хамаг орчлонгийн даяар дайдад би аялсан.  
Мянга мянган жил болсон ч цөхрөл үгүй хүлээх  
Миний үнэнч сэтгэл мэт цаг хугацаа хүлцэнгүй !”*

*~Эрин Зууны Хайр  
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай*